МАНАЙ СОНИНЫ IV УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MINFO.

19 дэх жилдээ

МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,163.139... ҮСХ-ны өгөгдлийн мэдээгээр

2017.09.12. Мягмар. №154 (4768) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР

Өдөр +21
Шөнө +5

ДЭЛХИЙ

БНХАУ-Д ТУРААХ ЭМ ХУУРАМЧААР ҮЙЛДВЭРЛЭЖ БАЙЖЭЭ

IV нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

БАССНЗҮРХ ДҮҮРГИЙГ ХОЁР ХУВААХ НЬ ЗӨВ, БУРУУ

V нүүрт

ИРЖ ЯВАА ЗАСГИЙН ГАЗАРТ ЭЧНЭЭ ХҮРГЭХ ҮГ

Б.СЭМҮҮН

Сүүлийн 17 жилийн хугацаанд хамгийн цөөн хоног /426 өдөр/засагласан Ж.Эрдэнэбатын Засгийн газар тахимаа өгч, МАН-ын бүлгийн 65 гишүүн шинэ Засгийн газраа бүрдүүлэхээр яарч байна. УИХ-ын төвшинд хоёр сар үргэлжилсэн нанчилдаан өнгөн дээрээ өндөрлөсөн ч ажиглагчид “Одоо нам дотроо илүү том зодоон болно” л гэлцэн анаж байна.

Гэвч энэ зодооны үр дүнд Засгийн газрыг огцруулахаар анхлан хөдөлсөн аваргууд хээр хонож, хоосон бэдрэх магадлал өндөр. Ерөнхийлөгчийн сонгуульд МАН ялагдсаны дараа энэ намын дараачийн дарга, Ерөнхий сайдаар эчнээ тодроод байсан, Шадар сайд асан У.Хүрэлсүхийн нэрийг лав төлөгчид жагсаалтын хамгийн сүүлд бичсэн байна.

Үргэлжлэл нь III нүүрт

Дугаарын 60 мөр

Цэцэрлэгт хүрээлэн эрүүлжүүлэх болчихож

Б.ЭРХЭС

Хүний бүтээсэн бүхний сайн сайхныг олж харахаас өмнө муу муухайгаар шүүмжиллээ хэмээн уншигч авхай та бүү бухимдаарай. Мэдээж тэнд гялтайх сайхан мэдээ, сайн жишиг байвал бид хамгийн түрүүнд танд дуулгах нь мэдээж хэрэг. Гэвч сайныг нь хэлэх ёстой хэмээн цаасан малгай өмсгөх гэхээс илүү дутагдлыг нь ил тод, шударгаар хэлж гэмээнэ алдаагаа хүн хурдан засч, өмнөхөөс илүү өөрчилж, сайжруулахаар зүтгэдэг учиртай. Тиймдээ ч улсдаа ганцхан байгаа Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн болж бүтэхгүй бүхнийг ил тодоор шүүмжлэхийг хүссэн юм. Хотын даргын шийдвэрээр ямар ч бүтээн байгуулалт хийгдээгүй хоосон талбайд байгуулагдаж байсан Үндэсний цэцэрлэгт хүрээлэн хоёр, гуравхан жилийн дотор итгэмээргүй өөрчлөгдсөн. Тэнд мод тарьж, зүлэгжүүлсэн. Хүүхдийн тоглоомын талбай, сагсан бөмбөг, гар бөмбөг, хөл бөмбөгийн талбайг нэгбүрчлэн байгуулсан. Дугуйн зам хүртэл бий болгож, хөшөө дурсгалыг ч хөрөнгө хайрлахгүй барьж байгуулж байлаа. Харамсалтай нь энэ бүхэн өнөөдөр бидний нүдний өмнө эвдэрч хэмхэрч эхэлжээ. Залуусын тоглож нааддаг сагсан бөмбөгийн талбайн голд борооны ус тогтож, хиймэл зүлэг нь хуурчихсан, урагдчихсан дүр зураг бүтэн зуны турш олны шүүмжлэлтэй тулгарлаа. Турник, савлуур зэргийг байрлуулсан талбайн голд мөн л бохир ус тогтож, хүн тоглох аргагүй байдалд хүрчихсэн байгаа.

Үргэлжлэл нь III нүүрт

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Багш нар АЖИЛ ХАЯХАА мэдэгдлээ

Б.ДАВАА

Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн төрийн өмчийн сургуулийн багш нарын цалингийн доод хэмжээг 1.6 сая төгрөг болгон нэмэгдүүлэх зорилгоор түр хороог байгуулсан. Түр хороонд эдүгээ Монгол орон даяарх аймаг сумын 30 гаруй мянган багш нэгдээд байгаа аж. Тэгвэл тус түр хороо байгуулагдсанаасаа хойш яг нэг сарын дараа хэвлэлийн бага хурал зохион байгуулж, өнгөрсөн хугацаанд гарсан ахиц хийгээд цаашид хэрэгжүүлэх алхмынхаа талаар мэдээлсэн юм. Хэвлэлийн хуралд Багшийн цалинг нэмэгдүүлэх түр хорооны Ерөнхий зохицуулагч Ц.Мөнхтуяа, Орхон аймгийн нэгдүгээр сургуулийн түүх, нийгмийн ухааны багш н.Отгонжаргал, Говь-Алтай аймгийн гуравдугаар сургуулийн технологийн багш Ж.Энхбаатар, Завхан аймгийн гуравдугаар сургуулийн гадаад хэлний багш Н.Лхагвасүрэн зэрэг 21 аймаг, сумдын багш нарын төлөөлөл оролцлоо.

Үргэлжлэл нь II нүүрт

ХААН банк

	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2442.00	2456.00	ФУНТ	3179.00	3257.00
ЕВРО	2902.00	2963.00	РУБЛЬ	41.70	43.70
ИЕН	22.34	22.75	ЮАНЬ	374.00	378.40

Худалдаа хөгжлийн банк

	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2442.00	2456.00	ФУНТ	3188.00	3273.00
ЕВРО	2914.00	2982.00	РУБЛЬ	41.86	44.28
ИЕН	22.28	22.94	ЮАНЬ	374.50	379.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

Зам тээврийн салбар үндэсний үйлдвэрлэлээ дэмжжээ

Зам, тээврийн хөгжлийн сайдын шуурхай өчигдөр хуралдаж, салбарын хэмжээнд шийдвэрлэх шаардлагатай, тулгамдаад буй асуудлуудын хүрээнд тодорхой үүрэг чиглэл өглөө. Зам, тээврийн салбарын зүгээс дотоодын үйлдвэрлэл, аж ахуй нэгжүүдээ дэмжих үүднээс үндэсний үйлдвэрлэлээ дэмжих бодлого баримталж, бүтээн байгуулалтын ажилд шаардагдах цементүүдээ үндэсний үйлдвэрлэгч аж ахуй нэгжүүдээс нийлүүлж байх талаар Зам, тээврийн хөгжлийн сайдын үүрэг гүйцэтгэгч Д.Ганбат харьяа байгууллагуудад үүрэг болгосон байна. Энэ хүрээнд Хөшигийн хөндий чиглэлийн хурдны автозамын бүтээн байгуулалтад "Мөнхийн баян гал" компаниас 22740 тонн цементийг нийлүүлсэн бол Баянхонгор-Байдраг чиглэлийн авто замын бүтээн байгуулалтад 4000 гаруй тонн, Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн авто замд 2000 гаруй тонн цементийг тус тус ашиглаж байгаа аж. Тус шуурхай хурлын үеэр салбарын удирдлагууд өвөлжилтийн бэлтгэл ажлыг нийт салбарын хэмжээнд шуурхай хангаж, холбогдох үйл ажиллагааг ажлын хэсгийнхэн шуурхай зохион байгуулах шаардлагатайг сануулласа. Мөн нүүрс тээвэрлэлттэй холбоотой асуудал, Цагаанхад боомтод үүссэн нөхцөл байдлын талаар судалж, нүүрс тээвэрлэлтийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарлаа хандуулах талаар холбогдох албан тушаалтнуудад үүрэг чиглэл өгөв. Энэ үеэр Замын-Үүдийн 60 айлын орон сууцыг төмөр замчдад хувьчлах ажлыг Японы талтай харилцан тохирсон тул төмөр замчдад орон сууцны гэрчилгээ олгох талаарх таатай мэдээг дуулгав.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

БАГШ НАР АЖИЛ ХАЯХАА МЭДЭГДЛЭЭ

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Хурлын эхэнд түр хорооны Ерөнхий зохицуулагч Ц.Мөнхтуяа "Монголын бүх багш нараа төлөөлж, 21 аймгийн багш нар Улаанбаатарт ирж, Үйлдвэрчний эвлэлийн хороонд уулзалт хийсэн. Уулзалтаар багшийн цалинг нэмэх асуудал Засгийн газрын төвшинд яригдахгүй, шийдэгдэхгүй байгаа учраас бид энэ байдлыг тэвчихгүй, эсэргүүцнэ гэдэг байр суурьт нэгдсэн. Цалинг нэмэх хүртэл нь тэмцэнэ. Өнгөрсөн сард бид Засгийн газарт шаардлага хүргүүлсэн. Шаардлагын хариу удахгүй ирэх ёстой. Тэр хариу ирээгүй тохиолдолд тэмцлийн дараагийн хэлбэр рүү шилжиж, орон даяар ажил хаяхаар төлөвлөж байна" гэлээ. Засгийн газарт хүргүүлсэн шаардлагад "Багшийн цалингийн доод хэмжээг 1.6 сая төгрөг болгох, багшийн цалинг тодорхой төвшинд тогтоон барих, боловсролын салбарын ажилчдын нийгмийн баталгааг сайжруулах" гэсэн гурван үндсэн зүйлийг тусгажээ.

Багш нарын цалинг нэмэгдүүлэх түр хорооны 21 аймгийн төлөөлөл УИХ-д суух 76 гишүүнд хаягласан шаардлагыг мөн хүргүүлж байгаагаа энэ үеэр мэдэгдсэн юм. Энэ талаар Орхон аймгийн дөрөвдүгээр сургуулийн газарзүйн багш Ж.Амгалан "Би Орхон аймгийн багш нарын цалинг нэмэгдүүлэх түр хорооны зохицуулагчаар ажиллаж байна. Өнөөдөр нэг багшийнхаа хамт Орхон аймгийнхаа ЕБ-ийн 24, цэцэрлэгийн 32 байгууллагын нийт 1800 багш нараа төлөөлж энд ирээд байна. 21 аймгийн багш нарын цалинг нэмэгдүүлэх түр хорооны төлөөлөгчид хуралдаад, биднийг төлөөлж ажилладаг УИХ-ийн гишүүдэд дэмжлэг хүсэх тухай шаардлагыг хүргүүлж байгаа. Монгол Улсын үе үеийн Засгийн газар цалингийн доод хэмжээг нэмнэ гэсэн амлалтаа биелүүлдэггүйн улмаас өнөөдөр сургуулийн багш, ажиллагсдын цалинг амжиргаанд нь хүрэлцэхгүй, худалдан авах чадвар өдрөөс өдөртдоройтсоорбайна.Тиймээс хөдөлмөрийнхөө үнэлэмжийг нэмэгдүүлэхийн тулд тэмцлийн хэлбэрт шилжихээс өөр аргагүй нөхцөл байдалд хүрч болзошгүй нь" гэж ярилаа. Дэлхийн багш нарын өдөр тун удахгүй буюу ирэх сарын 5-нд болох юм. Тэгвэл тус баяртай холбоотой үйл ажиллагаанд түр хорооны багш нар оролцохгүй гэдгээ хэвлэлийн бага хурлын үеэр онцолж байсан юм. Тэд нийт багш нартаа хандсан уриалга гаргасан байх бөгөөд түүнд "Дэлхийн багш нарын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд аливаа шагнал гардуулах, баярын үйл ажиллагаанаас татгалзаж, цалингаа нэмүүлэх төлөвлөгөөт үйл ажиллагаанд оролцохыг уриалж байна" гэжээ. Багш нарын шаардлагад төр, засгийн зүгээс нааштай хариу ирүүлээгүй тохиолдолд энэ өдөр багш нар баярлах бус, онц их хурал зохион байгуулах юм байна. Энэ үеэр Багш нарын цалинг нэмэгдүүлэх түр хорооны ерөнхий зохицуулагч Ц.Мөнхтуягаас зарим зүйлийг тодруулласа.

> ...Монгол Улсын үе үеийн Засгийн газар цалингийн доод хэмжээг нэмнэ гэсэн амлалтаа биелүүлдэггүйн улмаас өнөөдөр сургуулийн багш, ажиллагсдын цалинг амжиргаанд нь хүрэлцэхгүй, худалдан авах чадвар өдрөөс өдөртдоройтсоор байна...

> Ц.Мөнхтуяа: Хүүхэд илүү хохирохоос сэргийлэхийн тулд л бид тэмцэж байна

/Багш нарын цалинг нэмэгдүүлэх түр хорооны ерөнхий зохицуулагч/

-Шаардлагын хариу ирээгүй тохиолдолд тэмцлийн дараагийн хэлбэр рүү шилжинэ гэсэн. Энэ талаараа тодруулаач?

-Есдүгээр сарын 15-нд шаардлагын хариу ирэх ёстой. Хариу ирээгүй тохиолдолд бид Монголын үйлдвэрчдийн эвлэлийн холбоотойгоо хуулийн дагуу хамгаалалттайгаар ажил хаях хүртэлх тэмцлийн хэлбэрт шилжихээр тохиролцоонд хүрсэн байгаа.

-Засгийн газар огцорчихсон байгаа шүү. Шинэ Засгийн газар бүрэлдэж, шинэ сайд томилогдох хүртэл тодорхой хугацаа шаардлагатай байх. Засгийн газар байгуулагдахыг хүлээх үү?

-Хуулийн дагуу төрийн ажил тасралтгүй үргэлжлэх ёстой. Хэдий огцорсон ч, шинэ Засгийн газар бүрэлдэх хүртэл өнөөгийн Засгийн газар үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлнэ гэсэн заалт бий. Тиймээс дараагийн Засгийн газар байгуулагдахыг хүлээнэ гэсэн ойлголт байхгүй. Тэмцлээ үргэлжлүүлнэ.

-Багш нарын цалинг нэмэх боломж төсөвт байхгүй гэдгийг албаныхан хэлж байгаа. Энэ тухайд багш нар ямар бодолтой байгаа юм бол?

-Сангийн яамнаас маш буруу тоо гаргаж байна лээ. Ерөнхий боловсролын болон сургуулийн өмнөх боловсролын нийт 35 мянган багшийн асуудал яригдаж байгаа. Эхний ээлжинд самбарын өмнө хичээл заагаад зогсож буй багш нарынхаа цалинг нэмүүлье гэсэн шаардлагыг тавьж байгаа. Үүнийг төсөвт дарамт болохоор том тоо гэж бодохгүй байна. Бид дор бүрнээ гарц гаргалгааг хайж л байна. Гэхдээ бид хайх биш, тэд хайх ёстой шүү дээ. Гэтэл хайх ёстой хүмүүс ажлаа хийж чадахгүй байгаад харамсаж байна. Ямар нэг байдлаар багшийн цалинг нэм. Эс бөгөөс Монголын ирээдүй хойч чадвартай багшийн дутагдалд орлоо. Өнөөдөр сайн сурагчид багш мэргэжлийг сонгохгүй байна. Сарын 200 ам.долларын цалингаар хэн ч боловсролын салбарт ажиллахыг хүсэхгүй байгаа нь нууц биш. Боловсролын чанарыг сайжруулахын тулд багш нар хангалттай хэмжээний цалин авах ёстой. Бидний шаардлага зөвхөн цалингийн тухай асуудал биш. Монгол Улсын хувь заяаны тухай асуудал яригдаж байна.

-Улсын хэмжээнд хэчнээн багш түр хороонд нэгдсэн бэ. Ажил хаясан тохиолдолд бүх багш нар нэгдэнэ гэсэн үг үү?

-Монгол Улсад Ерөнхий боловсрол, сургуулийн өмнөх боловсролын 40 гаруй мянган багш бий. Бүгд түр хороонд нэгдсэн. Үйл ажиллагааг нь дэмжинэ гэдгээ илэрхийлчихсэн байгаа. Ажил хаялаа гэхэд улс орон даяарх багш нар ажил хаяна. Хотын багш нар ажил хаяад, орон нутгийн багш нар хичээлээ заана гэсэн ойлголт байхгүй.

-Хүүхдүүдийн хичээлийн хоцрогдлын яаж шийдэх вэ. Багш нар, төр хоёрын хооронд хүүхдүүд хохирчих юм биш үү?

-Хүүхдээ бид бодолгүй яах вэ. Халдварт өвчин ч юмуу, ямарваа нэг эрсдэлт хүчин зүйл тулгарахад сурагчдад зайны сургалт явуулдаг. Түүн шиг хичээлээ нөхөөд зайны сургалт явуулах чадвар манай багш нарт бий. Ийм ойрын жишээ ч байдаг. Хүүхэд илүү хохирохоос сэргийлэхийн тулд л бид тэмцэж байна. Өнөөдөр 200 ам.долларын цалинтай багш ажиллуулаад хүүхэд чанаргүй боловсрол эзэмших нь зөв юм уу, эсвэл хэдхэн хоног хүлээгээд багш нар хөдөлмөрөө шударгаар үнэлж, боловсролын системд илүү чадвартай, чанартай багш нар орж ирэх нь зөв үү. Хөндөгдөх л ёстой асуудал.

Хоккайдогийн технологийг Монголд нутагшуулах нь

Б.СУМЪЯА

"Монгол-Хоккайдогийн бизнес форум" Гадаад харилцааны яамны "Зөвшилцөл" танхимд боллоо. Хоккайдо муж нь Япон дотроо хүйтэн сэрүүн бүсэд тооцогддог, тэр хэрээрээ уур амьсгалын хувьд манай улстай төстэй. Иймд тус муж байгаль, цаг уурын онцлогтоо тохирсон технологитой бөгөөд үүнийг нь Монголд нутагшуулахад дөхөм аж. Тиймээс УИХ-ын гишүүн С.Болдын санаачилгаар уг мужтай хамтрах ажлыг эхлүүлж, нэг жилийн өмнө хоёр талыг зангидсан нэгдсэн байгууллага байгуулсан байна. Тус байгууллагын хүрээнд дээрх форум болж байгаа бөгөөд 30 гаруй хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид Японы талаас ирж оролцов. Хоккайдо, Монголын эдийн засгийн харилцааг дэмжих нийгэмлэгийн дарга Ц.Такэбэ, "Бидний зорилго бол Монгол Улстай тогтоосон эдийн засгийн харилцааг эрчимжүүлэх, бизнес эрхэлж байгаа болон бизнес эрхлэхийг хүсч байгаа аж ахуй нэгжүүдийг дэмжих юм. Өнгөрсөн хугацаанд Хоккайдод Монголын талаас олон удаагийн төлөөлөгч айлчилсан. Гэхдээ эдгээр уулзалтууд бүгд өөр өөр шугамаар хийгдэж байсан юм. Тиймээс асуудлыг нэгдсэн нэг удирдлагад оруулах нь чухал асуудал болсон. Үүний зэрэгцээ эдийн засгийн харилцаа гэдэгт зөвхөн бизнес эрхлэгчид хамрагдах биш, төр засгийнхнийг хамруулан дэмжлэг авах нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй гэж үзсэн. Өнгөрсөн онд гарсан хамгийн том ололт бол Хоккайдо, Монголын эдийн засгийн харилцааг дэмжих нийгэмлэгийг байгуулсан явдал байв. Монголын талыг УИХ-ын гишүүн С.Болд ахалж ажиллаж байна. Ингээд хоёр талаасаа бие биетэйгээ уялдаатай ажиллаад явж байна" гэлээ.

Харин форумын үеэр хөндөгдсөн асуудлын тухад ГХЯ-ны Ази, Номхон далайн орнуудын газрын захирал Э.Сарантогос, "Хоёр орны хооронд эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулагдаад нэг жил болж байна. Худалдааны эргэлт нэмэгдэж байна. Гэхдээ Монголын эдийн засагт далайцтай том өөрчлөлтийг авчрахын тулд дээрх хэлэлцээрийг хөшүүрэг болгон ашиглах ёстой. Тэр дундаа хоёр орны хувийн хэвшлийнхнийг таниулцуулах, улмаар японы технологийг оруулж ирэх, Монгол-Японы компаниуд хамтарч бүтээгдэхүүн үйлдвэрлэн дотоодын болон хөрш орнуудын зах зээлд гаргах зорилттой ажиллаж байгаа. Энэ хүрээнд өнөөдрийн зохион байгуулж буй форум маш чухал ач холбогдолтой. Форумын үеэр японы зарим компаниуд үйл ажиллагаагаа танилцуулж, Монголтой ямар чиглэлд хамтран ажиллах боломжтой вэ гэдгээ илэрхийллээ. Эдгээр чиглэл бүр нь манай улсад маш ойр, тэгсэн хэрнээ их чухал салбарууд байгаа юм. Тухайлбал, ХАА, газар тариаланг хөгжүүлэх чиглэлд нэгэн компани судалгаа хийсэн байна. Манай нөхцөлд тариа ногоо ургуулах нөхцөл хязгаарлагдмал байдаг. Гэтэл тус компани хөрсний дулааныг ашиглаад хавар гуравдугаар сараас намар арваннэгдүгээр сар хүртэл тариалалтын хугацааг уртасгах боломжтой гэдгийг судалж тогтоосон байна. Мөн аялал жуулчлалын компанийн төлөөлөгчид хүрэлцэн ирсэн байсан. Хоккайдо нь Токиогоос Монголтой орон зайны хувьд наана. Тиймээс тус муж руу шууд нислэг хийж, хоёр орны иргэд солилцоог нэмэгдүүлэхээр ажиллаж байгаагаа танилцууллаа. Түүнчлэн хүйтэн сэрүүний улирлын барилгын технологи гээд энэхүү бүс нутгаас суралцах зүйл их байгааг форумаас харж болохоор байлаа" хэмээв. "Монгол-Хоккайдогийн бизнес форум" Улаанбаатар хотноо ийнхүү хоёр дахь удаагаа амжилттай болж өндөрлөлөө.

УИХ-ын Тамгын газрын ажилтнууд номын дуу сонсчээ

УИХ-ын Тамгын газрын ажилтнууд, Хүний эрхийн дэд хороонд харьяалагддаг гишүүдийн зөвлөх, туслахууд өчигдөр Төрийн ордны Нээлттэй сонсголын танхимд зохион байгуулагдсан "Хүний эрхэд суурилсан хандлага" сэдэвт сургалтад хамрагджээ. Энэхүү сургалтыг УИХ-ын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Д.Цогтбаатар, Хүний эрхийн үндэсний комиссын дарга Ж.Бямбадорж, Улсын Их Хурлын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Э.Түвшинжаргал нар удирдсан юм. Сургалтыг нээж УИХ-ын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Д.Цогтбаатар "Хүний эрхийн асуудал бол төрийн амин сүнс нь юм. Үндсэн хуулийн бүтэн нэг бүлэгт хүний эрхийн асуудал багтдаг. Төрийн оршин тогтнох гол үндэс нь Монгол Улсын иргэн бүр эрх чөлөөтэй, айх аюулгүй, ажилтай, суралцах, эрүүл энх амьдрах боломжоор хангагдах явдал юм. Төрийн үйл ажиллагаатайхолбогдож,хүний эрхийн асуудал байнга гарч байдаг. Тиймээс төрийн албан хаагчид энэ асуудалд онцгой анхаарч байх ёстой. Энэхүү сургалтыг бид цаашид тогтмол зохион байгуулж байх нь хүний эрхийг хүндэтгэх, төрийн албан хаагчдын ёс зүй, харилцааны соёлыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой учраас цаг үеэ олсон арга хэмжээ болж байна гэж бодож байна" хэмээн хэлжээ. Дараа нь Хүний эрхийн үндэсний комиссын дарга Ж.Бямбадорж "Үндсэн хууль дах, хүний эрхийн хамгаалалт болон Монгол Улс дахь хүний эрхийн нөхцөл байдал" сэдвээр илтгэл тавьсан байна. Мөн Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн П.Оюунчимэг "Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилт ба хүний эрхийг хамгаалах олон улсын механизм", "Эрүү шүүлтээс ангид байх эрх чөлөө" сэдвүүдээр илтгэл тавьжээ.

Реклам, зар сурталчилгааны алба: 99173710

ҮЗЭЛ БОДОЛ

ИРЖ ЯВАА ЗАСГИЙН ГАЗАРТ ЭЧНЭЭ ХҮРГЭХ ҮГ

...Уг нь бол "Засаг ажлаа хийж чадахгүй байна" гээд огцруулсан хүмүүст өөрсдөд нь хариуцлагыг үүрүүлээд юу хийхийг харах ёстой юм. Ингэж байж тэр хүн түмний төлөө дуугарсан уу, төрсөн биеэ гэсэн үү? гэдгийг харах боломжтой. Гэвч ам алдвал барьж болдоггүй хойно яалтай...

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Ердөө жил гаруйн өмнө "АН засаглаж чаддаггүй" хэмээн баалж, манай нам ялбал цагийн байдал ч тогтворжоод, эдийн засаг ч сэвхийгээд босоод ирэх юм хуна гэлцэж байсан МАН-ынхан эрх мэдлийн хаалга татангуутаа хөнжилдөө хөлөө жийлцээд, засгаа татаж унагаад эхэлсэн нь даанч харамсалтай. Ийм болсон намаас ихийг хүлээх шаардлагагүй ч юм шиг.

Атал нөгөө талаас Засгийн газраа огцруулахдаа МАН-ын бүлгийн гишүүдийн хэлсэн, ярьсан зүйл бийг бас мартаж болохгүй. "Готов нь авна уу, Шадав нь авна уу" гэгчээр хэнийгээ томилохоо нам нь мэддэг юм байгаа биз. Гэхдээ хэн нь засгаа тэргүүлж, хэрхэн бялуугаа хуваахаас үл хамааралд ядаж л огцруулсан Засгийн газраасаа давж ажиллах ёстойг тэд мартсан байлаа ч бусад нь сануулах ёстой. Хамгийн наад зах нь сайд нараа томилохдоо хэн их мөнгө төлснөөр нь биш, хэн нь энэ салбарыг илүү мэдэх вэ гэдэг дээр төвлөрч шийдвэрээ гаргах ёстой болж байна. Одоо л эл дол болоод мартагдах тийшээ хандаж яваа болохоос биш Ж.Эрдэнэбатын танхимыг анх байгуулж байх үед салбартаа тэнцэх сайд тийм олон байгаагүй юм. Барилга барьдаг Б.Чойжилсүрэнд улсын сан хөмрөгийн түлхүүр атгуулж, боловсролын бодлогоо Ж.Батсуурьт бариулна гэж хэн ч төсөөлөөгүй л байлаа, тэр үед.

Дээр нь хоёр нам /АН, МАН/ хамтарч засаг байгуулахдаа цомхотголд оруулаад орхисон дэд сайдын орон тоог МАН дангаараа нугалаад оруулаад ирнэ чинээ хэн нь саналаа. Энэ бүхэн эцсийн дүндээ нөгөө 60 тэрбумын л хаялга болж харагдаж байв. Хэрэв 60 тэрбумын санхүүгийн схемийг Засгийн газрыг байгуулахад бус, УИХ-ыг бүрдүүлэхэд ашигласан гэвэл, энэ схемээр орж ирсэн 65 хүний ашиг сонирхлыг нэг бүрчлэн гүйцэлдүүлнэ гэвэл нэг байтугай нэлээн хэдэн Засгийн газар хүрэлцэхгүй юм.

Тиймээс засаг байгуулж, буулгаж тоглож байгаа МАН-ын олонхид сануулахад "60 тэрбумын" гэх зайгуул нэрээс ангижрахыг хүсвэл хамгийн түрүүнд салбартаа илүүдэж, төсөвт дараа болсон дэд сайд нараасаа салж үзээрэй дээ. Сайдын эзгүйд семинарын илтгэл танилцуулах, суудал бөглөхөөс өөр эрхэлсэн ажилгүй, эрх мэдэл ч үгүй дэд сайдын албан тушаал МАН-ын үед твитерээр хэрүүл хийхээс өөр боловсролгүй сайтын эрхлэгч, улс төрийн тавцангаас өнөд буусан хуучин кадруудад хангамж эдлүүлдэг халамжийн суудал болоод байгаа.

Дээр нь "Албан тушаал горилсондоо бид Засгийн газраар оролдоогүй, сайдын суудалд шунаагүй шүү" гэж ам андгай тавьсан МАН-ын 31 гишүүн /Т.Аюурсайхан, Сү.Батболд, Б.Баттөмөр, Б.Батзориг, Х.Болорчулуун, Ж.Ганбаатар, Д.Гантулга, Ц.Гарамжав, Ц.Даваасүрэн, Д.Дамба-Очир, Г.Занданшатар, Д.Лүндээжанцан, Х.Нямбаатар, Ц.Нямдорж, Л.Оюун-Эрдэнэ, М.Оюунчимэг, Ш.Раднаасэд, Д.Сарангэрэл, Д.Сумъяабазар, Г.Солтан, Я.Содбаатар, А.Сүхбат, Д.Тогтохсүрэн, Н.Учрал, Ч.Хүрэлбаатар, Д.Цогтбаатар, С.Чинзориг, Б.Энх-Амгалан, Л.Энхболд, Л.Элдэв-Очир, Ө.Энхтүвшин, Ж.Энхбаяр/ нар шинэ Засгийн газарт сүүдрээ бүү унагаарай даа. Хэрэвзээ 2020 оны сонгуулиар энэ танхимдаа эргэж орж ирье гэвэл.

Уг нь бол "Засаг ажлаа хийж чадахгүй байна" гээд огцруулсан хүмүүст өөрсдөд нь хариуцлагыг үүрүүлээд юу хийхийг харах ёстой юм. Ингэж байж тэр хүн түмний төлөө дуугарсан уу, төрсөн биеэ гэсэн үү? гэдгийг харах боломжтой. Гэвч ам алдвал барьж болдоггүй хойно яалтай. Давхар дээл, давхар дээл гэж харгирч хашгирчихаад өөрөө давхарлаад өмсчихдөг нөхөд ч өмнөх Засгийн газруудад олон л байлаа. Долоон компанийнхаа концессоо далуулаа хуваагаад идчихжээ гэж сонсогдвол бас л нэг эмгэнэл.

Түүхий эдийн үнэ дэлхийн зах зээл дээр өсөөд төрийн оролцоогүйгээр эдийн засаг урсгалаараа сэргэж, төсвийн орлогыг өдөр өдрөөр зузаатгаж байгаа энэ үед эрх барьж байгаа намын ганц үүрэг нь тэр мөнгийг шаардлагатай салбарт нь зөв зүйтэй хуваарилах л асуудал шүү дээ. Энэ ажлаа л хариуцлагатайхан хийхийн оронд дотогшоо ярьдаг асуудлаа гадагшаа хашгираад, гадагшаа яриад ирсэн ажлаа дотооддоо зодолдож унагаад байвал гавьяа болохоосоо гай удахын л нэмэр.

Эцсийн бүлэгт 2016 оны УИХ-ын сонгуулиар сонгогчид АН-ыг МАН-аар сольсон шалтгаан нь улс төрийн тогтвортой байдал. Ашиг сонирхлын зөрчилтэй АН-ын олон фракцийг МАН гэдэг нэгдмэл цул хүчнээр сольж, эрх мэдлийг нь тултал нь өгөөд хариуцлагыг нэг мөр үүрүүлэх гэсэн л сонголт байсан. МАН сая Засгийн газраа огцруулснаараа энэ сорилтод аль хэдийн нэг удаа бүдэрчихээд байна. Тиймээс одоо байгуулах Засгийн газар нь мандуулаад тэнгэрт тулдаггүй юм гэхэд онхолдуулаад газартай тэгшилчихэлгүй ирэх гурван жилийг даагаад гарах бууртай, суурьтай байх ёстой болж байна. Сая хуралдсан ээлжит бус чуулган шиг амных нь салиа арилаагүй "бандааштай" банди нар энэ намын өнгө болж, явах замыг чиглүүлнэ гэвэл жинхэнээсээ "нохойн наадам" болоод өнгөрөх талтай.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ

Дугаарын 60 мөр

Цэцэрлэгт хүрээлэн эрүүлжүүлэх болчихож

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Хөшөө дурсгалын хөл нь хугарсан, цуурсан гэх мэтээр хаашаа ч харсан бүх зүйл нь ундуй сундуй. Энд чин сэтгэл, арчилгаа дутагдаж буй нь илхэн. Уг нь энд маш олон хүмүүс ажилладаг. Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, харуул хамгаалалтад олон ч хүмүүс ажиллаж байгаа нь харагддаг ч иргэдийн тохитой амарч, зугаалах боломжийг хангаж өгөөгүйг шүүмжлэхгүй байх арга алга. Хамгийн муухай нь энд өнөөх гудамжны архичин, танхай этгээдүүд хаа сайгүй явцгааж байх юм. Нэг биш нэлээд хэдэн удаа ийм хүмүүстэй таарсан учраас бичихгүй, шүүмжлэхгүй сууж чадахгүй нь. Архичдын оромж аятай хүүхдүүдийн тоглож байсан модны дор согтуу нөхөр хурхиран унтаж байхтай саяхан тааралдлаа. Аяга халуун цай уух гэж согтуу залуугийн хоол горьдсон харцанд ээрүүлж, элдвээр хэлүүлж суугаа залуу гэр бүлтэй ч мөн тааралдав. Бэлэн бүтээгдэхүүн, хуушуур зарж буй ТҮЦ-ний ойр орчимд хоол горьдсон согтуучууд суучихаад идсэн хуушуурных нь үлдэгдэлтэй хэрүүл зарга үүсгэж байхыг хэлэхгүй өнгөрч боломгүй байлтай. Хэдийгээр бүх нийтээр үйлчлүүлэх ёстой цэцэрлэгт хүрээлэн боловч ая тухтай амарч зугаалах эрхийг нь хангаж өгөх учиртай бус уу. Мод дэрлэн унтаж буй согтуу этгээд нялх балчир үрсийг минь айлгаж ичээвэл хэрхэх билээ. Хоол горьдсон согтуу нөхөр хуушуурны гурил өгсөнгүй хэмээн танхайрвал бас яах вэ.

Энэ мэтээр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд хяналт гэж зүйл алга болжээ. Ажиллах гэж цалин авч байгаа бол сэтгэл гаргах ёстойсон. Арчилж тордоод, хяналт тавиад явчихвал болохгүй зүйл алга. Гэтэл тэнд ажиллаж байгаа хүмүүс, тэнднийг удирдаж байгаа даргын аль алинд нь чин сэтгэл дутагдсан нь энэ мэт зүйлээс харагдаж байх юм. Хотын битүү утаа, түгжрэлд бухимдсан иргэдийн зорьж очиж амардаг, дугуй унадаг, тоглодог, модны үнэрт тухалдаг таатай орчныг бүрдүүлэх учиртай энэ газар хар зах шиг болчихоод байгаа юм. Хаа сайгүй хуушуур, шорлогны эхүүн утаа. Хямдхан тоглоомын хар зах ажиллаж байгааг нуух аргагүй. Ямар ч хяналтгүй зарагдаж байгаа хуушуур нь юуны махаар хийснийг бурхан л мэдэж байх. Хөгшин настай аав минь хоёр хуушуур идчихээд хоёр хоног хоолны хордлогод орж сэхээнд орох шахаж байлаа. Энэ мэтээр тэнд хяналт, хариуцлага гэдэг зүйл алдагджээ. Энэ газрыг Нарантуул захын боссын охин удирддаг гэдгийг бид мэднэ. Нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгч эрхэм хатагтай танд дахиад л хов дуулгая. Дороо ажиллаж буй хүмүүстэй хариуцлага ярьяач. Дэлхийд номер нэгт орох үндэсний цэцэрлэгт хүрээлэнг маань эрүүлжүүлэх битгий болгооч гэж гуйя. Эвдэрсэн тоглоом, халтайсан хөшөөг нь арчилж тордоод өгөөч. Эрүүл ахуйн шаардлага хангасан хоол хүнстэй, нялх балчир үрсийн минь аюулгүй байдлыг хангасан тоглоомтой болгож өгөөч. Ингэж шүүмжилж суухаар орохоо больчих гэж хэн нэгэн их мэдэгч шүүмжлэх л байх. Гэвч бид үйлчлүүлэхээ болилоо гээд нөхцөл байдал өөрчлөгдөхгүй бол маргааш хэн нэгэн ингэж бухимдах нь тодорхой юм. Тэнд чин сэтгэл л дутагдаж байна.

ДЭЛХИЙ

Бангладешийн Гадаад хэргийн сайд: Мьянмарт геноцид болж байна

Зэвсэгт мөргөлдөөн үргэлжилж буй Мьянмараас үндэстний цөөнх болох лалын шашинт рохинжа овгийнхон дүрвэж, хөрш Бангладешийг зорих болжээ. Хамгийн сүүлд авсан мэдээллээр аль хэдийнэ 300 гаруй мянган иргэн Бангладешт очсон ажээ.

Тэгвэл үүнтэй холбогдуулан Бангладешийн Гадаад хэргийн сайд мэдэгдэл хийж, энэ үеэр "Мьянмарт геноцид болж байна" хэмээжээ.

Гадаад хэргийн сайд Абул Хассан Махмуд Али нийслэл Дака хотод гадаадын дипломат ажилтнуудыг хүлээн авч уулзсаныхаа дараа хэвлэлийн хурал зарлаж, "Мьянмарын зэвсэгт мөргөлдөөнийг Олон улсын нийгэмлэг геноцид гэж хэлж байна. Бид ч гэсэн геноцид гэж үзэж байгаа" гэж ярьсан байна. Тэрбээр Бангладешт суух АНУ, Европ, Арабын дипломат ажилтнууд, НҮБ-ын салбар байгууллагын төлөөлөлтэй уулзаж, Мьянмарын рохинжа овгийнхонд хүмүүнлэгийн тусламж үзүүлэхийг хүссэн байна. Мөн энэ үеэр өнгөрсөн хоёр долоо хоногийн хугацаанд Бангладеш руу дүрвэсэн рохинжа иргэдийн тоо 300 мянгад хүрч, нийтдээ 700 мянган дүрвэгч тус улсад ирээд буй тухай танилцуулжээ. Мьянмарт болж буй мөргөлдөөнөөр 3000 хүн амь үрэгдсэн гэх мэдээлэл мөн байгаа юм. Өнгөрсөн сарын 25-нд Роханжагийн зэвсэгт босогчид Мьянмарын цэргийн хүчинд цохилт өгсөн юм. Улмаар тус улсын арми хариу цохилт өгч эхэлснээр, Мьянмарт зэвсэгт мөргөлдөөн үүсч, олон мянган хүн амиа алдаад байна.



АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшин өрсөлдөөд өвдөг шороодсон Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон "CBS" телевизэд ярилцлага өгчээ. Тэрбээр өнөөгийн Ерөнхийлөгч Доналд Трампад сонгуульд ялагдсан, өнөөдрийг хүртэлх бэрхшээл, сэтгэлийн зовнил зэргээ ний нуугүй уудлан ярьсан байх бөгөөд дахин сонгуульд өрсөлдөхгүй гэдгээ ч мэдэгдсэн байна. Хиллари "миний хувьд сонгуулийн өрсөлдөөн дуусан" хэмээжээ.

Түүний мөн л сонгуулийн ололт, тулгарсан бэрхшээл зэргээ олон нийтэд илчлэн бичсэн "What Happened" ном өнөөдөр хэвлэлтээс гарах юм. Тиймээс номын маркетингийн хүрээнд улстөрч бүсгүй тус нэвтрүүлэгт оролцсон аж.

Тэрбээр сонгуулийн ялагдлаа "Одоо ч гэсэн хэцүү санагдаж байна. Үнэхээр хэцүү" хэмээсний зэрэгцээ "дахин сонгуульд нэр дэвшихгүй. Улстөрчийн карьер дуусан" гэж ярьжээ. Клинтон АНУ-ын том улс төрийн намаас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшсэн анхны эмэгтэй улстөрч болж чадсан юм. Гэвч, үүгээр түүний улстөрчийн карьер дуусгавар болсон аж.

БНХАУ-Д ТУРААХ ЭМ ХУУРАМЧААР ҮЙЛДВЭРЛЭЖ БАЙЖЭЭ

Б.ДАВАА

Манай орны хувьд хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүнийхээ 70 хувь, аж үйлдвэрийн барааны 90 хувь, шатахуун, техник, төхөөрөмжийг 100 хувь гадны орноос импортлодог. Үүний дотор хүнсний нийт бүтээгдэхүүний 20-иос илүүтэй хувийг урд хөршөөсөө импортолдог юм. Тэгвэл тус улсад хуурамчаар тураах эм үйлдвэрлэж байсан зөрчил илэрсэн байна. БНХАУ-ын Хунань мужийн Лоуди хотын захиргаа тус хотын нийтийн аюулгүй байдлын товчоо болон хүнс, эмийн бүтээгдэхүүний хяналтын газар хамтран явуулсан шалгалтаар хүний биед хортой бодис ашиглан хуурамч тураах эм үйлдвэрлэн, худалдаж байсан зөрчил илэрсэнийг олон нийтэд зарлаад байна.

> ...Лоуди хотын Хүнс, эмийн хяналтын газрын дарга Хоу Дифаны хэлж буйгаар сибутрамин нь төв мэдрэлийн системд сөргөөр нөлөөлж, хоолны дуршлыг дарангуйлах үйлчилгээтэй бодис гэнэ. Улмаар даралт ихэсгэх, зүрхний цохилтын тоо олшрох, хоолонд дургүй болгох, нойргүйдэх, элэгний үйл ажиллагааг гэмтээх зэргээр хүний биед ноцтой хохирол учруулах эрсдэлтэй юм байна...

Хунань мужийн Иян хотоос 20 километр алслагдсан ууланд 20 гаруй насны залуус хааш хаашаа 10 метр. кв талбайтай жижиг өрөөнд нэг цагт 10 мянган ширхэг хортой хуурамч тураах эм үйлдвэрлэн, худалдан борлуулж байжээ. Лоуди хотын цагдаагийн газар хууль бус эмийн үйлдвэрлэлийн гол цэгт нь шалгалт хийж, холбогдох сэжигтнүүдийг баривчилсан аж. Хэсэг залуусын хувиараа үйлдвэрлэж, худалдан борлуулсан тураах эм нь 19 өнгийн капсултай нийтдээ 100 мянган хайрцаг бөгөөд нийт дүн нь 100 сая юаныг давжээ. Цагдаа нар одоо хотын бүх зах, худалдааны төвүүдэд шалгалт хийж, хуурамч эмийг хурааж байгаа аж. Хуурамч тураах бүтээгдэхүүнтэй холбоотой мэдээллийг Алибаба худалдааны сайт цагдаад мэдэгдсэнбайна.Тускомпанийн хуурамч бүтээгдэхүүний хяналтын багийн ахлагч Чен Ли Хунань мужийн нутаг дэвсгэрт "Green" гэх тураах эм интернэтээр худалдаалагдаж байсныг илрүүлсэн тухайгаа мэдэгджээ. Улмаар найрлагад нь хууль бус, хортой бодис орсон байж болзошгүй гэж үзэн цагдаад мэдэгдсэн аж. Харин цагдаагийн газар хэргийг хагас жил орчим хугацаанд мөрдөн шалгасны эцэст гэмт хэрэгтнүүдийг үйлдэл дээр нь баривчилсан гэнэ. Цагдаагийн газраас мэдээлснээр, энэ удаагийн хэрэгт холбогдон саатуулагдсан залуус Хунань мужийн Иян хотоос гаралтай байжээ. Тэд хоёр жилийн өмнөөс хуурамч тураах эм үйлдвэрлэн, интернэтээр дамжуулан худалдаалж, их хэмжээний ашиг олдог байсан аж.

Сэжигтнүүд Гуандун, Зежианаас капсул дүүргэгч машин, эмийн найрлагад орсон бодис, капсул, сибутрамин зэргийг худалдан авч, ууланд байрлах байшиндаа хуурамчаар үйлдвэрлэдэг байсан байна. Сибутрамин гэх бодис нь хар тамхины төрлийнх бөгөөд тарган, жин ихтэй хүмүүсийн хоолны дуршлыг бууруулах зорилгоор хэрэглэдэг гэнэ. Гэвч, уг бодис нь хүний биед маш муу сөрөг нөлөөтэй аж. Үүнийг хэргийн сэжигтнүүд мэдсээр байж, хуурамч бүтээгдэхүүн үйлдвэрлэлдээ ашигладаг байжээ.

Лоуди хотын Хүнс, эмийн хяналтын газрын дарга Хоу Дифаны хэлж буйгаар сибутрамин нь төв мэдрэлийн системд сөргөөр нөлөөлж, хоолны дуршлыг дарангуйлах үйлчилгээтэй бодис гэнэ. Улмаар даралт ихэсгэх, зүрхний цохилтын тоо олшрох, хоолонд дургүй болгох, нойргүйдэх, элэгний үйл ажиллагааг гэмтээх зэргээр хүний биед ноцтой хохирол учруулах эрсдэлтэй юм байна. БНХАУ-д 2010 онд сибутрамин болон түүний найрлагатай эмийн үйлдвэрлэл, худалдаа, ашиглалтыг хориглосон юм.

Есдүгээр сарын 11-ний террорист халдлагаас хойш 16 жил өнгөрчээ

АНУ-ын бахархал болсон Нью-Йоркийн ихэр цамхагийг 2001 оны есдүгээр сарын 11-ний өглөө 19 алан хядагч онгоцоор мөргөн нурам болгож, хэн ч хэзээ ч халдаж чадахгүй хэмээгддэг Пентагоны зургаан талт барилга руу хүртэл довтлон дэлхий нийтийг "шоконд" оруулж байсан билээ. Тэрхүү хар өдрөөс хойш 16 дахь жилийн ойн өдөр өчигдөр тохиолоо. Тухайн үед "Аль Каида" бүлэглэлийн 19 гишүүн АНУ-ын иргэний агаарын тээврийн дөрвөн онгоцыг барьцаалсан бөгөөд тэдний хоёр нь Нью-Йорк хотод орших Дэлхийн худалдааны төвийн ихэр цамхагийг ээлж дараалан мөргөж дэлбэрсэн юм. Харин гурав дахь онгоц нь Виржина муж дахь Пентагоны барилгад гэмтэл учруулсан бол дөрөв дэх онгоцонд сууж явсан иргэд алан хядагчдаас онгоцны удирдлагыг авах гэж оролдон бүтэлгүйтэж Пенсильвани мужийн Шанксвиллд унасан байдаг. Ийнхүү террористууд тавхан цагийн дотор ихэр цамхагийг сүйрүүлж дэлхий нийтэд аймшигт дурсамжийг үлдээсэн билээ. Энэхүү алан хядах ажиллагааны улмаас 3000 орчим хүн амиа алдаж, 6000 гаруй хүн шархдан, хамгийн багаар бодоход 10 тэрбум ам.долларын хохирол учирчээ. Түүнчлэн амиа алдагсад дан ганц АНУ-ын иргэд байсангүй, дэлхийн 90 гаруй орны иргэд байсан юм. Америкчууд тухайн үедээ хамгийн өндөр барилгын тоонд багтдаг байсан ихэр цамхагийн суурин дээр Есдүгээр сарын 11-ний дурсгалын музейг босгосон юм. Энэхүү музей нь АНУ-д болсон томоохон хэмжээний тэрхүү террорист ажиллагааны баримт сэлтийг хойч үедээ таниулах зорилготойгоор босгосон цогцолбор юм.

Ирма хар салхины улмаас нас барагсдын тоо 30-ыг давлаа

Асар их хор хөнөөлт Ирма хар салхи өчигдөр АНУ-ын Флорида мужид хүрсэн. Харин салхины хүч нь өмнөхөөсөө харьцангуй суларсан ч, хүний амь насанд аюул учруулах хэмжээнд байгаа тул онц байдлаа үргэлжлүүлсээр байна.

АНУ-ын цаг уурчдын мэдээлснээр, хар салхийг хүчнээс нь хамааралтай I-V зэрэгт хуваадаг бөгөөд "Ирма" хар салхины хүч одоо II зэрэгтэй байна. Энэ хар салхи 183.6 км/ц-ийн хурдтайгаар урагшилж байгаа аж. Карибын тэнгисийн арлууд, тэдгээрийн дотор Сен-Мартен аралд энэ хар салхины улмаас нийтдээ 27 хүн амиа алджээ. Харин Флоридад өчигдөр гурван хүн нас барснаар байгалийн гамшгийн улмаас нас барагсдын тоо 30-д хүрлээ.

Мөн Мексикийн өмнөд хэсэгт хар салхины улмаас ширүүн бороо орж, хоёр сая орчим хүн цахилгаангүй болжээ. Хар салхины улмаас өргөн уудам талбайг хамарсан хүчтэй салхи хөдөлснөөр барилгын крануд унаж, мод үндсээрээ булгарч унасан байна. Флоридагийн томоохон хот болох Майамигийн зам талбай ч усанд автжээ.



ОНЦЛОХ ХУУДАС

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙГ ХОЁР ХУВААХ НЬ ЗӨВ, БУРУУ

Эсрэг тэсрэг байр суурь

А.Даваажаргал: одоогоор хуваах боломж байгаа эсэхийг судалж байгаа

/Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга/

...Дүүрэг хуваах асуудлыг хуулиараа УИХ шийддэг. Нийслэлийн Засаг даргын хувьд Баянзүрх дүүргийг хуваах боломжийг судлах ажлын хэсэг байгуулах захирамж гаргасан. Уг ажлын хэсэгт Баянзүрх дүүргээс хэд хэдэн хүн бий...

Дүүрэг хуваах асуудлыг хуулиараа УИХ шийддэг. Нийслэлийн Засаг даргын хувьд Баянзүрх дүүргийг хуваах боломжийг судлах ажлын хэсэг байгуулах захирамж гаргасан. Уг ажлын хэсэгт Баянзүрх дүүргээс хэд хэдэн хүн бий. Одоогоор зөвхөн хуваах боломж байгаа эсэхийг судалж байна. Эцсийн шийдийг УИХ гаргана. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд Баянзүрх дүүргийн Засаг даргын үүргийг Д.Пүрэвдаваа гүйцэтгэж байсан. Саяхан өөр ажилд шилжиж байгаа учир Засаг даргын үүрэгт ажлаас чөлөөлж өгнө үү гэсэн өргөдлөө өгсөн. Нийслэлийн Засаг дарга өөрийнх нь хүсэлтийн дагуу захирамж гаргаж, ажлаас нь чөлөөлсөн. Хотын даргын хувьд Баянзүрх дүүргийг яаралтай Засаг даргатай болгох зорилт тавьж байна. Хуулийн дагуу шаардлага хангасан хүний нэрийг өргөн баривал батламжлахад бэлэн.

Н.Батцэнгэл: Дүүргийг хоёр хуваавал иргэд дэмжинэ гэж бодож байна

/Баянзүрх дүүргийн 13 хорооны иргэн/

-Дүүрэг удирдлагагүй өчнөөн удлаа. Төрийн байгууллагын ажил цалгардаж байна. Хэсгийн дарга нараас эхлээд шат шатны байгууллагын төрийн албан хаагч нар ажлаа хийхгүй байна. Хүнд суртал, улс төржилт газар аваад байгааг эсэргүүцэж байна. Яаралтай удирдлагаа томилох хэрэгтэй байна. Манай дүүрэг 300 гаруй мянган хүн амтай маш том дүүрэг. Дүүргийг хоёр хуваахад иргэд дэмжинэ гэж бодож байна. Сонгинохайрхан дүүрэг хоёр хуваагдана гэсэн асуудал яригдаад байхад манай дүүргийг хоёр хуваах яагаад болохгүй гэж. Нөгөө талд гэтэл хороодын хэсгийн дарга нар хоёр хуваахгүй гэж жагсаж байна. Түүнээс иргэд бол хоёр хуваахгүй гэж жагсаагүй шүү дээ.

...Баянзүрх дүүрэг нийт 28 хороотой, 320 мянган оршин суугчтай. Хэрэв дүүргийг хоёр хуваах юм бол бүх иргэдийн иргэний үнэмлэхний хаяг солигдоно. Бүх үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ солигдоно. Шинээр захиргааны байр барина, шинэ орон тоо нэмэгдэнэ гээд олон ажил хийх болно...

Т.Батцогт: Дүүрэг хуваах гэж байхаар тэр мөнгөөрөө цэцэрлэг, сургууль бариач

/Баянзүрх дүүргийн Засаг даргын орлогч/

БЗД-ийн Засаг даргын орлогч НИТХ-ын төлөөлөгч Т.Батцогт “Баянзүрх дүүрэг орон нутгийн ээлжит сонгуулиас хойш Засаг даргаа томилуулж чадалгүй бүтэн 10 сар боллоо. Учир нь 2016 оны аравдугаар сарын 19-ний өдөр улс орон даяар зохион байгуулагдсан орон нутгийн ээлжит сонгуулийн үр дүнгээр Баянзүрх ИТХуралд Ардчилсан Намаас нэр дэвшсэн 22 нэр дэвшигч, Монгол Ардын Намаас нэр дэвшсэн 19 нэр дэвшигч хамгийн олон сонгогчийн санал авч тус дүүрэгт Ардчилсан нам олонхи болсон. Иймд анхдугаар хуралдаанаа зарлан 53.7 хувийн ирцтэй хуралдаж олонхийн санал авч сонгогдсон 41 төлөөлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрч, хурлын дарга, тэргүүлэгчдээ сонгосон юм. Засаг даргад нэр дэвшигчээ тодруулж, түүнээс хойш зургаан удаа хуралдаж дүүргийн нийгэм, эдийн засгийн олон асуудлыг шийдвэрлэсээр өнөөг хүрсэн. Харамсалтай нь дүүргийн Засаг даргад нэр дэвшигчийг тодруулж Нийслэлийн Засаг даргад удаа дараа уламжилсан боловч томилолгүй өнөөдрийг хүрлээ. Нийслэлийн Засаг дарга дүүргийн Засаг даргыг томилохгүй байгаа шалтгаанаа дараах байдлаар тайлбарлаж, хууль зөрчсөөр байна. Т.Баясахыг дүүргийн Засаг даргаар томилуулахаар дахин нэр дэвшүүлсэн тул томилох шийдвэр гаргуулж төрийн ажлын гацааг гаргаж, дүүргийн ИТХ-д нийгэм, эдийн засгийн асуудлаа бие даан шийдвэрлэх хуулиар олгогдсон эрхээ эдлэх боломжийг олгоно уу гэж хүсэх байна. Томилох эрх бүхий албан тушаалтан Хурлын тогтоолыг хүлээн авснаас хойш таван өдөрт багтаан томилох шийдвэр гаргах үүрэгтэй. Баянзүрх дүүргийг хоёр хуваах асуудлыг Нийслэлийн Засаг дарга биш иргэд мэднэ. Энэ асуудалд нухацтай хандах нь зөв. Түүнчлэн ямар ч асуудалд иргэдийн эрх ашиг нэгдүгээрт байх ёстой. Баянзүрх дүүрэг нийт 28 хороотой, 320 мянган оршин суугчтай. Хэрэв дүүргийг хоёр хуваах юм бол бүх иргэдийн иргэний үнэмлэхний хаяг солигдоно. Бүх үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ солигдоно. Шинээр захиргааны байр барина, шинэ орон тоо нэмэгдэнэ гээд олон ажил хийх болно. Бид үүнийг урьдчилсан байдлаар тооцоолж үзэхэд, 40 гаруй тэрбум төгрөгийн зардал гарахаар байгаа. Өнөөдөр Улаанбаатар хотод хамгийн тулгамдсан асуудал дүүрэг хуваах ажил мөн үү. Баянзүрх дүүргийг 40 тэрбум төгрөгөөр хуваахынхаа оронд тэр мөнгөөр цэцэрлэг, сургууль бариад өгөөч. Өнөөдөр 100 хүүхдийн багтаамжтай төрийн өмчийн цэцэрлэгийг нэг тэрбум төгрөгөөр барьж байгаа. Сая хичээлийн шинэ жил эхлэхэд олон хүүхэд цэцэрлэгийн сугалаанд хамрагдаж чадахгүй, 40 орчим мянган хүүхэд гэртээ үлдэж хоцорсон. Энэ мөнгөөрөө сургууль, цэцэрлэг барьж, ядаж хүүхдүүдээ цэцэрлэгт бүрэн хамруулмаар байна.

Сэтгүүлчийн дүгнэлт

АЛБАН ТУШААЛЫН ШАГНАЛД ӨГӨХ ШИНЭ ДҮҮРЭГ ХЭРЭГ БОЛОО ЮУ

Н.ПУНЦАГБОЛД

Орон нутгийн сонгуулийн дараачаас эхлээд л бөөн асуудал араасаа дагуулсан дүүрэг бол Баянзүрх. Засаг даргаа томилж чадахгүй бараг л жил болж байна. Тиймдээ ч ард иргэдээсээ авахуулаад төлөөлөгчид нь хүртэл Засаг даргатай болгож өгөхийг шаардаж байгаа. Бүр жагсаал цуглаан зохион байгуулж хүртэл үзсэн. Уг нь сонгуулиар АН 22, МАН 19 суудал авсан. Гэвч АН-аас дэвшүүлж байгаа Засаг даргыг батламжлахгүй байгаа нь асуудал болоод байгаа юм. Гэхдээ энэ асуудал цаашаа явсаар бүр сүүлдээ Баянзүрх дүүргийг хоёр хуваах дээрээ тулж байх шиг байна. Бүр дүүргийг хоёр хуваагаад, Дүнжингарав гэж нэрлэх санал хүртэл гарсан гээд байгаа. Баянзүрх дүүргийн иргэд хүртэл ийм санал гаргажээ. Арай Засаг даргаа сонгож чадахгүй дээрээ тулчихсан АН, МАН-ын төлөөлөгчид дүүргээ салгаж аваад, нэг нэгээрээ засаглах гэж бодоогүй л байлтай. Дүүрэг хуваах гаргалгаа нь их энгийн. Ердөө л 300 мянга давсан иргэнтэй учраас хуваах ёстой гэж хараад байгаа бололтой юм. Хэрвээ хуваачихвал 150 мянган хүн амтай хоёр том дүүрэг болох юм байх аа. Хамгийн гол нь дүүрэг хуваалаа гээд иргэдэд хүрэх төрийн, нийгмийн үйлчилгээ хурдан шуурхай болж, төгөлдөржиж чадах бил үү. Цэцэрлэггүй гэртээ сууж байгаа багачууд СӨБ-д хамрагдаж чадах уу. Юу өөрчлөгдөх вэ гэдэг асуулт байна. Тэгвэл энэ асуултад өгөх ганц л хариулт байгаа. Юу ч өөрчлөгдөхгүй. Дүүргийн иргэдийн тал нь шинээр бичиг баримтаа солиулна. Цаашлаад, дүүргийн Засаг даргын тамгын газрын байр сав. Төрийн үйлчилгээ үзүүлэх газрууд хэрэгтэй. Дээрээс нь бас баахан дарга, цэргийн орон тоо гарч ирнэ. Тэдний цалин хөлс гээд маш их зардалтай. Албаны хүмүүс бол 40 тэрбум төгрөг хэрэгтэй гэж ярьсан байна билээ. Зарим нь бүр 100 тэрбумын асуудал ч яриад байгаа. Хэд ч байсан гэсэн асар их мөнгө. Тийм их мөнгө зарцуулж, дүүрэг хувааж яана аа. Энэ талаар судалж байгаа юм билээ. Судлаад ч хэрэггүй шүү дээ. Одоохондоо манай улсад дүүрэг хуваж, мөнгө үрээд байх тийм их хөрөнгө байхгүй. Түүний оронд дүүргийн Засаг даргыг хэл амгүй томилоод, батлаад, ажлыг нь эхлүүлэх хэрэгтэй биз дээ. Дээрээс нь тэгж л их үрэх мөнгөтэй юм бол Баянзүрх дүүрэгтээ хэдэн цэцэрлэг барьчихаач дээ. Эсвэл төрөх эмнэлэг ч юм уу. Улаанбаатар хотод хийх шаардлагатай, шийдэх ёстой ажил өч төчнөөн л байна. Түүний номер нэгт дүүрэг хуваах байх ёсгүй байх аа. Эсвэл энэ олон даргад шагначих албан тушаал дутагдаад, ганц хоёр дүүрэг нэмэх гээ юу. Тэгээд Засаг дарга, цаашлаад баахан газрын даргын суудлыг зарах гээгүй л бол дүүрэг нэмж яана. Манай улсад даргаас их юм алга. Төрийн ажлыг цалгардуулж, түмний татварын мөнгөөр тоглосон, юу ч хийдэггүй хурган дарга нараар дүүрчихээд байна. Тийм байтал дахиад нэг дүүрэг нэмээд, баахан даргатай болчихвол яах болж байна аа, энэ чинь. Дарга нарынхаа дороос босохгүй юм болох байлгүй. Мэдээж дүүрэг хуваах асуудлыг хэдэн хүн яриад ч юм уу, нийслэл дээр хуралдаад шийдчихгүй нь тодорхой. УИХ-аар хэлэлцүүлнэ, батална. Хуваатал бас өдий байна л даа. Гэхдээ юмыг яаж мэдэх билээ. МАН үнэмлэхгүй олонх. УИХ, нийслэл дээр ялгаагүй олуулаа. Нэг дарга нь санал оруулаад, нөгөөх нь дэмжээд, олонхиороо шийдээд явчихвал Баянзүрх дүүргийг голоор тасалчихад юу байхав.

ОРОН НУТАГ

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

“СЭЛЭНГЭ-2017”-ООР ХОЁР УЛС ХАМТРАН ТЕРРОРИЗМТЭЙ ТЭМЦЭХ АРГАЧЛАЛЫГ БОЛОВСРУУЛНА

Г.ГАНЧИМЭГ
М.ДАВААДУЛАМ

Орос, Монгол хоёр улсын зэвсэгт хүчний хамтарсан “Сэлэнгэ-2017” байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулилт Дорноговь аймагт амжилттай болж өндөрлөлөө. Энэхүү хээрийн сургуулилт энэ жил 10 дахь удаагаа болж буй ч Зүүнбаянгийн цэргийн ангийг түшиглэн говь хээрийн нөхцөлд зохион байгуулагдсанаар онцлогтой юм. ЗХЖШ-ын I орлогч дарга, хошууч генерал Р.Сүхбат “Жилээс жилд сургуулилтын агуулга, оролцож байгаа цэргийн албан хаагч, техникийн тоо өсч байдаг. Энэ жил хоёр улсын талаас 240 техник, 1000 гаруй цэргийн албан хаагч оролцсон. Энэ удаагийн сургуулилтаар бид хоёр улсын хил дагуу хууль бус зэвсэгт хүчинтэй хоёр улсын зэвсэгт хүчин хамтарсан тэмцэл явуулах арга техникийг боловсруулж байна. Сүүлийн үед дэлхийн халуун цэгүүд дээр болж эртний зохион байгуулснаараа өнөөдөр Монголын зэвсэгт хүчний хэрэглэж буй зэвсэг техник хоцрогдоогүй байна гэдгийг харлаа” хэмээн ач холбогдлыг нь тодотголоо.

Манай улсын зэвсэгт хүчинд Т-55, Т-72, А гэх мэт танкууд бий. Энэ жил удаан хугацааны хадгалалтад байсан зэвсэг, техникүүдээ шинэчлэн сайжруулж, хээрийн сургуулилтад үндсэн техникүүдээ ашиглажээ. Харин Оросын талаас Т-72, БТР, БМП-2 зэрэг танк, бусад зэвсэг техникийг ашигласан юм. Болзошгүй эрсдэл дунд зэвсэг техникээ зөв, оновчтой ашиглах арга, харилцан туршлага суралцахаас гадна хээрийн сургуулилт маш олон талын ач холбогдолтой. Энэ сургуулилтад оролцохын тулд цэргийн албан хаагчид хамгийн багадаа хагас сар хээрийн бэлтгэлд гарчээ. Ингэснээр энх цагийн цэргийн албан хаагчид хоорондоо нөхөрлөж, бие биенээ хүндэтгэн хоёр улсын харилцаа сэргэжбайна. Сүүлийн үед манай улсын цэргийн албан хаагчид ч олон улсын цэргийн ажиллагаа, энхийг сахиулах үйлсэд оролцож, туршлага хуримтлуулж байгаа. Энэ хэмжээгээрээ Оросын цэргийн албан хаагчдад үлгэр дууриал үзүүлэх, энхийг дэмжих ажиллагаанд оролцож байсан туршлагаа хуваалцах гэх мэтээр хоёр талт сургалт, туршлага солилцох аяллуудыг хийжээ.

Хоёр улсын Батлан хамгаалах яаманд БНХАУ-ын талаас албан ёсны хүсэлт тавьсны дагуу энэ жил Хятадын цэргийг ажиглагчийн статусаар оролцуулсан юм. БНХАУ-аас Монгол Улсад суугаа цэргийн атташе, ахлах хурандаа Бао Юу Хай “Сүүлийн үед терроризм дэлхий нийтийг түгшээсэн асуудал болж хувирч байна. Монгол, Хятад, Орос гурван улс хамтран терроризмын аюултай тэмцэх шаардлагатай. Тиймээс цаашид гурван улсын хамтарсан цэргийн хээрийн сургуулилт зохион байгуулахыг

> ...Хоёр улсын Батлан хамгаалах яаманд БНХАУ-ын талаас албан ёсны хүсэлт тавьсны дагуу энэ жил Хятадын цэргийг ажиглагчийн статусаар оролцуулсан юм. БНХАУ-аас Монгол Улсад суугаа цэргийн атташе, ахлах хурандаа Бао Юу Хай “Сүүлийн үед терроризм дэлхий нийтийг түгшээсэн асуудал болж хувирч байна...

сургуулилтад анх удаа Хятадын талаас ажиглагчийн байр суурьнаас оролцлоо” гэв.

буй зэвсэгт мөргөлдөөнүүд, ялангуяа, Сирийн ажиллагаатай холбоотойгоор хууль бус зэвсэг, техникийн арга хэрэгсэл нэлээд нарийсч байгаа юм. Тиймээс манай улсын зэвсэгт хүчинд цэргийн алба хаагчдын хувьд энд боловсруулсан зэвсэгт тэмцэл явуулах арга хэлбэр шинэлэг байлаа. ОХУ дэлхийд хоёрдугаарт эрэмбэлэгддэг, хүчирхэг зэвсэгт хүчинтэй. Сүүлийн үед террористуудтай тэмцэл явуулахад нэлээд туршлагажсан орон. Ийм улсын цэргийн албан хаагчдаас манай улсан цэргийн албан хаагчид нэлээд зүйлийг сурч байна. Мөн энэ сургуулилтыг

Дарийн утаа суунаглахад төрсөн бодол

Дэлхийн II дайнаас хойш дарийн утаа үнэрлэж үзээгүй 2-3 үеийнхэн Монголд төрж өссөн. Дайн, байлдаан, зэвсэгт мөргөлдөөн гэдэг хүн хүсээд байх зүйл биш ч өнөөдөр дэлхийн халуун цэгүүдэд болон хаа нэгтээ хууль бус зэвсэглэл, хорлон сүйтгэх ажиллагаа, зэвсэгт халдлага болж, энхийг сахиулах үйлсэд Монголын цэргийн алба хаагчид оролцож байгаа. Гэвч бидний дийлэнх нь дайны талбар, галын шугмын талаар эндүү ташаа ойлголт, мэдлэг мэдээлэлгүй байдаг. Ийм учраас л сүүлийн үед цэргийн хээрийн сургуулилтыг олон нийтэд нээлттэй явуулдаг болжээ. Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин ч төрийн албан хаагчид болоод энгийн иргэдээ хээрийн сургуулилт очиж үзэхийг үүрэг болгосон нь нүдээ олов бололтой. Тэнд цугларсан энгийн иргэд “Дээр үед “Иргэний хамгаалалт”-аар л буу угсрах, задлах, буудах хичээл ордог байсан”, “Босгосон байнуудыг эхнээс нь буудаж унагаад, бүгдийг устгаад явдаг юм байх гэж бодсон чинь үгүй юм байна”, “Ном зохиол дээр л “Цагаан тугаа өргөлөө” гэж бичсэн байдаг нь ийм учиртай юм байна шүү дээ”, “Ийм юмнаас амьд гарна гэдэг аймаар л юм байна” гэх мэтээр хоорондоо ярилцаж, өөрт төрсөн бодол сэтгэгдлээ хуваалцаж байлаа. Алсаас том, том үхэр чулуу шиг харлан харагдах байнуудыг явган цэрэг, танк гэх мэтээр тус тусад нь зориулж босгосон гэдгийг сургуулилтын төгсгөлд зарим нь мэдсэн юм. Тэднийг шууд л дайрч ороод хамаа замбараагүй буудаад байх юм шиг ойлголттой явснаа ярьж, толгой сэгсрэх хүн ч байна. Бид эх орныхоо үнэ цэнэ, цусан гавьяа байгуулсан эрэлхэг хөвгүүдээ үеийн үедээ мартдаггүй ч хүн гэдэг ямар мартамхай, бас дасамтгай амьтан бэ гэдгийг эхний буун дуунаар л давхийн цочихдоо олон хүн ухаарсан биз ээ.

Л.Баатар : Манай зэвсэг, техник хоцрогдоогүй

Орчин үед учирч болзошгүй цэргийн үйл ажиллагааны бодит байдалд ойртуулж, боловсруулсан бодлого төлөвлөгөөтэй, гурван үе шаттай, хоёр улсын хамтарсан хээрийн сургууль хоёр орны цэргийн алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, тэсвэр тэвчээр үүрэг гүйцэтгэх чадварыг говь хээрийн бүсэд шалгаж, бас нэгэн шинэ туршлага болж үлдлээ. Тэртээ 40 жилийн өмнө Монгол, Оросын хамтарсан “Говь-77” хээрийн сургууль энэ нутагт болж байсныг Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа Л.Баатар ярьж байна.

-Энэ жил говь хээрийн нөхцөлд хоёр улсын хамтарсан хээрийн сургуулилтыг хийлээ. Цэргийн 1000 гаруй алба хаагч оролцсон гэхээр зохион байгуулалтын ажил нэлээд нүсэр байсан болов уу?

-Олон цэргийн анги, байгууллага Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт байдаг. Өмнөд талаараа БНХАУ-тай 600 гаруй км-ээр хиллэдэг. Хилийн гурван отряд, агаарын довтолгооноос хамгаалах цэргийн агаарын хилийг хардаг гурван салбартай. Онцгой байдлын олон газар, хэлтэстэй. Мөн Зэвсэгт хүчний ... дугаар анги гээд олон цэргийн анги байдаг. Уламжлалаараа ч гэсэн хуучин Зүүнбаянгийн нэгтгэл, анги гэж том дивиз 1960-аад оноос 1990-ээд он хүртэл байсан. Түүхэн уламжлалаас нь сөхвөл “Говь-77” гэж хээрийн сургуулилт 1977 оны наймдугаар сарын 23-29-нд Дорноговь аймгийн Сайхандулаан, Дундговь аймгийн Өндөршил сумын нутагт болсон байдаг. Тус тактикийн хээрийн сургуулилтад тэр үеийн Монголын ардын армийн тусгай анги нэтгэлүүд, Зөвлөлтийн армийн Өвөр байгалийн цэргийн тойргоос мөн тусгай анги, хорооны хүч бүрэлдэхүүн орсон байдаг юм. Үүнээс хойш үе шаттай сургуулилт хийгдэж байсаар өнөөдөр дөчин жилийн дараа энэ хээрийн сургуулилт боллоо. Энэ сургуулилт болохтой холбоотойгоор хуурай цэргийн командлалаас аймаг, орон нутагт “Ийм сургуулилт болох гэж байна” гэдгийг танилцуулсан. Аймаг, орон нутгийн удирдлагууд ард иргэдийн хамтаар энэ сарын 18-нд сургуулилтад оролцох орос цэргүүдийн эхний цувааг тосч авсан. Олон жил уулзаагүй хүмүүстэйгээ уулзаж байгаа юм шиг дотно сэтгэгдэл төрж байлаа. Мөн наймдугаар сарын 29-ны өдөр дараагийн цувааг хүлээн авч, тэдэнд хүндэтгэл үзүүлсэн. Ингээд наймдугаар сарын 30-ны өдөр нээлт болсон юм. Хээрийн сургуулилт есдүгээр сарын 6-нд амжилттай явагдаж дуусласа. Олон нийтэд нээлттэй зохион байгуулсан нь бүс нутгийн цэрэгжилт, батлан хамгаалах, аюулгүй байдал ямар чухал вэ, хууль бус зэвэгт мөргөлдөөн, эх оронд самуун үүсвэл ямар хор хөнөөлтэй вэ гэдгийг тод томруун харж ухаарсан болов уу. Ингэснээр хүмүүс хоёрыг бодож, нэгийг тунгааж, батлан хамгаалах, эх орны аюулгүй байдлыг хангана гэдэг бол хэн нэгэн цэргийн хувцас өмссөн хүмүүсийн ажил биш бид бүгдийн хамтын ажилагаа юм гэдгийг мэдэрч ойлгож байна.

-Гэхдээ 40 жил гэдэг чинь их урт хугацааны дараа болсон байна. Манай батлан хамгаалах салбарын зэвсэг, техник ЗХУ-ын үед л авсан нэлээд хуучирч муудсан гэдэг ойлголт ард иргэдэд байдаг шүү дээ. Хээрийн сургуулилтад ямар зэвсэг, техникийг ашиглав. Шинээр нэмэгдэж ирсэн зүйлүүд нь юу байсан бэ?

-Монголын Ардын армийг өргөтгөн зохион байгуулж, 1980-аад оны үед авсан зэвсэг техник нь 1960-1970 оны зэвсэг, техник байгаа. Эдгээр нь ашиглалтын хугацаа нь дуусан ч гэдэг юм уу эсвэл хуучин загвартай, ашиглаж болохгүй гэсэн зүйл байхгүй. Ер нь дайн самуун үүсэхэд хүн өөрт байгаа зэвсгийг маш сайн ашиглаж чаддаг байх чадварыг л эзэмших ёстой болохоос биш заавал шинэ технологийн зэвсэг техник чухал биш. Цэргийн хээрийн сургуульд оролцсон Т-55 танк, явган цэргийн байлдааны машин байна. Зенитийн 23-ын суурьт пулемёт “Катюшик” байна. Энэ бүгдийг өнөөдөр манайд ашиглаж байгаа. Эдгээр нь өнөөдөр хоцрогдоод болохоо байчихаагүй. Сүүлийн үед хоорондоо холбоо мэдээлэл солилцох гар радио станц гээд шинэ дэвшилтэт техникүүд ч орж ирсэн.

НИЙГЭМ

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

ХААН ЖИМСНИЙ ОХЬ БОЛСОН “ХУБА ХАЯА”-ТАЙ НЭГ ӨДӨР

...“Бид чацарганы үр болон зөөлөн эдийн тосыг ялган гаргаж авдаг. Энэ тосыг гадаадын гоо сайхны компаниуд бүтээгдэхүүн үйлдвэрлэлдээ зориулан захиалж авдаг. Мөн энэ тос нь эрүүл мэндэд маш их ач тустай...

Б.ТОГТОХ

Жил бүрийн есдүгээр сарын эхэнд нийслэлчүүдийн хүсэн хүлээдэг, гэр бүлээрээ зорьж очдог нэгэн баяр бол “Хаан жимс” компанийн хамт олны зохион байгуулдаг “Чацарганы баяр” юм. Өдгөөгөөс найман жилийн өмнө ах дүү, танилын хүрээнд цомхон хийж байсан энэхүү баяр жил бүр улам л өргөжин тэлсээр багахан сумын наадам шиг өргөн хүрээнд зохион байгуулагддаг болжээ. Товлосон цагт, тогтсон газраа гэдэгчлэн өнгөрөгч ням гарагт ах дүү, анд найзууд бүгдээрээ Улаанбаатар хотоос 54 км-ын зайнд байрлах “Хаан жимс” амралтын газарт уулзлаа. Хурсан олон чацарганы баярт тун ч ач холбогдол өгсөн нь илхэн. Оранж өнгийн хувцсаар гэр бүлээрээ гоёж, бас уралдаан тэмцээнд оролцох бэлтгэлээ ч дор бүрнээ хангаж иржээ. Жил бүрийнх нь баярт оролцоор ирсэн сэтгүүлчдийн баг ч өглөө эртлэн нийслэл хотоос хөдөлж, бага үдийн хэрд амралтын газарт очлоо. Ирсэн зочдын хувьд дөнгөж эхний жилдээ оролцож буй нэгэн байхад, бүр найман жил тасралтгүй оролцож байгаа хүмүүс ч олон байсан юм. Энэ жилийн хувьд илүү өргөн хүрээнд зохион байгуулж, тусгайлан барьсан асар, том тайз засч, мөн чацаргана жимсээр хийсэн кекс, боорцог, амтат хуушуур, шорлогоор дайлж, ирсэн зочдоо өлсгөхгүй, уйдаахгүй байхаар бүх зүйлийг зохион байгуулсанд талархаж буйгаа иргэд хэлж байлаа. Чацарганы баярыг нээж “Авьяаслаг монголчууд” шоуны шилдэг оролцогчдын нэг болох “Алтай” хамтлаг ая дуугаа өргөлөө. Морин хуурын аялгуугаар эхэлсэн баярын үйл ажиллагаа уралдаан тэмцээн, дуу хуураар үргэлжлэв. Хүүхдийн ордоны авьяаслаг багачууд бүжгийн үзүүлбэр үзүүлсэн бол, баярын хамгийн бяцхан оролцогчид тайзны өмнө эгнэн зогсчихоод бүжиглэж буй нь хүн бүхний хайрыг татаж, басхүү энэ өдрийн нэгэн сонирхолтой үйл явдлын нэг болсон юм. Мөн энэ өдөр хүүхэд багачуудын дунд “Хуба хаяа” гэх үгний утгыг тайлбарлах уралдаан зохион байгуулав. Тэмцээнд оролцсон хүүхэд бүр “Хаан жимс” компанийн брэнд бүтээгдэхүүний нэр ямар учиртайг өөр өөрийн сонссон, мэдсэнээр тайлбарлаж, зарим нь тайзнаас шууд шүлэг уншиж, дуу дуулан инээд хөөр бэлэглэв. “Хуба хаяа” гэх үг нь Чингис хаантай холбоотой аж. ОХУ-ын эрдэмтдийн судалж тогтоосноор “Хаан жимс” амралтын газар нь Чингис уулын өвөр бэлд бууриа засчээ. Тэр ч байтугай энэхүү газар нутагт Их Эзэн Чингис хааны асар олон түүх, бэлгэдэл агуулагдаж байдгийг нэрт сэтгүүлч Г.Бадамсамбуу ирсэн зочдод тайлбарлаж өгөв. Хуба Хаяагийн тухай “Монголын нууц товчоо”-нд тэмдэглэгдэн үлдсэн түүхийг эргэн сөхвөл “...Чингис хаан, тэнд тайчуудыг довтолж Аучу баатар, Ходун орчан, Худуудаар зэргийн тайчуудын язгуртныг ургийн ураг хүртэл үнсэн товрог болгож хядав. Улс иргэний нь нүүлгэж Чингис хаан Хуба Хаяа гэдэг газар ирж өвөлжив” гэж бичсэн нь байдаг аж. Хоёр ч удаа их дайны дараа өвөлжиж, амралт авч дараа нь аян дайнд ялж байсан түүхийг хүүхдүүд өөр өөрийн дуулсан мэдсэнээр тайлбарлалаа. “Улаан хаяа” буюу “Хуба хаяа” хэмээх энэ газар нь Туулын орчимд байгаа “Хаан жимс” амралтын газрын бууриа зассан төгөл гэдгийг олон ч судлаачид баталсан гэдэг. Энэхүү түүхийг зөвөөр тайлбарласан долоон хүүхдийг “Хаан жимс”-ийнхэн бүтээгдэхүүний дээж болон сурагчийн хичээлийн хэрэгслээр шагнаж урамшуулсан юм.

Н.Алтанхуяг: Дархлааны алтан жорыг гарган авсандаа баяртай байна

“Хаан жимс” компанийн хувьд өнгөрсөн жилээс эхлэн чацаргана жимсний хальс, үр хоёрыг нь ялгаж, үлдсэнийг нь савлаж худалдаанд гаргаж эхэлсэн билээ. өөрөөр хэлбэл, ямар ч сайхан, нэмэлт бодис ороогүй органик, шууд модноос нь түүж савласан эко бүтээгдэхүүн гэсэн үг. Зах зээлд гараад нэг жил болсон ч эрүүл органик бүтээгдэхүүн гэдгээр хэдийнэ олны таашаалд нийцсэн “Хуба хаяа” өнөө жил савалгаагаа томсгож, мөн төрөл зүйлээ ч нэмжээ. Залуужуулж, дархлаажуулж, тамиржуулах байгалийн хаан жимснээс гаргаж авсан хүч чадлын охь болсон энэхүү бүтээгдэхүүнийг гэр бүлийн хэрэгцээнд зориулан нэг литрийн том савалгаатай болгосноо “Хаан жимс”-ийнхэн энэ өдөр ирсэн зочиддоо танилцуулав. Тус компанийг үүсгэн байгуулагч, Монгол Улсын Ерөнхий сайд асан, Ерөнхийлөгчийн улс төрийн бодлогын зөвлөх Н.Алтанхуяг чацаргана жимснээс бид дархлааны алтан жорыг гаргаж авсан хэмээн онцлов. Тэрбээр хурсан зочдод хандан хэлсэн үгэндээ “Хаан жимсний чацарганаас гаргаж авсан “Хуба хаяа” нь байгалийн цэвэр бүтээгдэхүүн бөгөөд чацаргана нь жимсний хаан юм гэдгийг дэлхий улс орнууд хүлээн зөвшөөрдөг. Бид энэхүү жимснээс дархлааны алтан жорыг гарган авч, монголчуудыгаа дархлаажуулж, эрүүлжүүлж байгаадаа туйлын баяртай байна. Монголчууд дэлхийн тавцанд ноолууран бүтээгдэхүүнээсээ гадна удахгүй “Хуба хаяа”-гаараа танигдана гэдэгт итгэж байна. Япон, Солонгос, Хятадын худалдан авагчид Монголын эрүүл хөрсөнд ургасан чацарганыг Евро стандартаар бүтээгдэхүүн болгон гаргаж буй технологид огтхон ч эргэлздэггүй. Хуба Хаяа бол Монголын эрүүл хөрсөнд ургасан, бордоогүй чацарганаас ялгаж авсан охь. Чацарганы хальс, үрийг нь ялгаад, ус сахар нэмэхгүйгээр шууд савлаж байгаа. Тиймээс байгалийн витамины хаан гэж хэлж болно. Бид энэхүү бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлд гаргахаар ажлаа эхлүүлээд явж байна. Олон ч томоохон үзэсгэлэнд оролцлоо. Мөн худалдаж авах сонирхлоо ч тэд илэрхийлж эхэлсэн. Тун удахгүй хаан жимсний охиор бид дэлхийг дайлах нь ээ. 50 мл хэмжээтэй “Хуба хаяа” гэхэд л хүний бүтэн өдрийн А, С, Е, витамины хэрэгцээг бүрэн хангах бөгөөд дархлаажуулан, эрүүлжүүлэх ид шидтэй” хэмээлээ. Харин үйлдвэрийн инженер Д.Ганзориг “Бид чацарганы үр болон зөөлөн эдийн тосыг ялган гаргаж авдаг. Энэ тосыг гадаадын гоо сайхны компаниуд бүтээгдэхүүн үйлдвэрлэлдээ зориулан захиалж авдаг. Мөн энэ тос нь эрүүл мэндэд маш их ач тустай. Үрийн тос нь тархины судас нарийсах өвчнийг эдгээдэг бол зөлөн эдийн тос нь зүрх судасны системийг эрүүлжүүлдэг омегаг илүү ихээр агуулдаг учир бид өдөр тутамдаа хэрэглэж занших нь зүйтэй юм” гэв. Бүтэн нэг өдрийн турш дуу хуур, инээд наргиан, эрүүл органик хаан жимсийг шууд модноос нь түүж амталсан зочид орой галын наадамд оролцож, шинэхэн жимсээр саваа дүүргэн ирэх жилийн энэ цагт уулзах болзоо тавин тарж одлоо. Дараа жил дахиад шинэ түүхтэй, шинэ брэндтэй, илүү их амжилттай эргэн уулзах нь дамжиггүй биз ээ.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

ХААИС-ийн уулзварыг албан ёсоор нээлээ

Хан-Уул дүүрэг, 11-р хороо, ХААИС-ийн уулзварын өргөтгөл, шинэчлэлтийн ажил дуусч, өчигдөр уулзварыг нээлээ. Хуучин гурван эгнээ байсан уулзварыг бүх талд нь таван эгнээ болгон өргөтгөж, байнга баруун эргэх боломжтой болгон шинэчлэх ажлыг “Улаанбаатар Зам засвар арчлалтын газар” ОНӨААТҮГ гэрээт хугацаандаа хийж гүйцэтгэжээ. Тус уулзвар нь 1975 онд ашиглалтад орсноос хойш өргөтгөл шинэчлэлийн ажил хийж байгаагүй бөгөөд өргөтгөл шинэчлэлт хийснээр замын зорчих хэсгийн өргөн 12-13 метр, таван эгнээ болжээ. Мөн уулзварын нэвтрүүлэх чадвар хоёр дахин нэмэгдэж, замын хөдөлгөөний ачаалал буурч, иргэдийн аюулгүй байдал сайжирч, зорчигч, тээвэрлэгчдийн цаг хугацаа, шатахуун хэмнэх, ая тухтай байдлыг бүрэн хангах боломжтой болж байгаа юм байна.

902 тонн бодис, 1500 тонн давс нөөцөлнө

Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн өчигдөр боллоо. Хуралдааны эхэнд Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Т.Гантөмөр нийслэлийн өвөлжилтийн бэлтгэж ажлын явцыг танилцууллаа. Нийслэлийн 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд нийт 1231 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, өнөөдрийн байдлаар 82 хувийн гүйцэтгэлтэй байгаа аж. Эрчим хүчний эх үүсвэр буюу дулааны цахилгаан станцуудын өвөлжилтийн бэлтгэл есдүгээр сарын 6-ны өдрийн байдлаар 81, инженерийн хангамжийн байгууллагуудын бэлтгэл 84 хувьтай байгаа аж. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газрууд өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 236 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, 81 хувийн биелэлттэй байгаа юм байна. Үүнээс гадна, Улаанбаатар хотын дулааны төв шугамд нийт 12 зогсолт хийхээс засварын ажил төлөвлөгөөний дагуу хийгдэж, есдүгээр сарын 5-ны өдрийн байдлаар 11 зогсолт бүрэн хийгдэж дуусаныг Ерөнхий менежер танилцууллаа. Мөн 2017-2018 онд өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 902 тн бодис, 1500 тн давс нэмж нөөцлөхөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулан ажиллаж байгаа ажээ.

Өрхийн халаалтыг ирэх баасан гарагт өгнө

Нийслэлийн хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл 85 хувьтай байна. Энэ хүрээнд айл өрхүүдийн халаалтыг энэ сарын 15-наас буюу ирэх баасан гарагаас, албан байгууллагын халаалтыг ирэх сарын 1-ний өдрөөс өгөхөөр болжээ. 2017-2018 оны халаалтын улиралд гэр хороллын 120 мянган хэрэглэгчийг шөнийн хэрэглээний тарифын хөнгөлөлт үзүүлэх аж. Дулаан хангамжийн хувьд энэ жилийн халаалтын улиралд 41 ширхэг хэсэгчилсэн болон ганцаарчилсан халаалтын тогоог зогсоож, төвлөрсөн дулаан хангамжид холбосноор 56 мянган тонн түүхий нүүрсний хэрэглээг бууруулж, агаарын бохирдлыг 10 хувиар бууруулах боломжтой юм байна.

ЗАВСАРЛАГА

Улаанбаатарт:

Маргааш

Өдөр +23
Шөнө +8

Нөгөөдөр

Өдөр +22
Шөнө +9

Өдрийн зурхай

НАМРЫН ТЭРГҮҮН ШАР БИЧ САРЫН НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХАР БАР ӨДӨР

Үс засуулбал:
Идээ ундаа элбэг олдоно.
Наран ургах, шингэх:
06.31-19.11

Тухайн өдөр морь, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмтнийг шийтгэх, сан тавиулах, угаал үйлдэх, амьлуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, тангарагаа буцаахад сайн. Золиг гаргах, бомбын үйл, сэтгэлд сэвтэй газар очих, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргэлжлэх буюу засуулбал эд, эдлэл, идээ, ундаа олно.

Бидэнд тохиолдсон

ХҮНДХЭН ХӨГТЭЙ ЯВДЛУУД

Jess Shaman Fratellino

Гурван ахын буянаар ч гэхүү, балгаар ч гэхүү. Гурван удаа хонхны баяр хийхдээ нэг ч удаа шинэ костюм өмсөж үзээгүй юм даа. Хонхны баяр болгонд томдож, таарсан хослолтой л гүйж явна. Оюутан болоод овоо өсөөд харин ч нэг сайхан даа. Ах нарынхаа аль өнгөтэй өөдтэйг нь нууцаар ч нэг, хэлээд нэг өмсөж өгнө шүү дээ. Ха ха. Шарандаа ажилд орсон даруйдаа өөртөө яг таарсан хослол авч билээ. Над мэтийн нөхөд байдаг л байхдаа. Хэ хэ.

Books

"Ном" буланд тавтай морил

ИХ ГЭРИЙН ЭЭЭГТЭЙ

Үргэлжлэл.
Түрүүч нь №153 дугаарт

Дараа нь хоёул хамжин салны нөгөө талаас өргөсөнд бөөрөнхий мод дээгүүр сал амархан гулсав. Салны дороос бөөрөнхий мод гарч дахиад эхнээс нь давтан хийлээ. Энэ бол хамаг тэнхээ барсан хүнд ажил болохоор салыг усны хөвөөнд аваачих үед хөлөрсөн нүүр нь гялалзаж байлаа. Энэ бүх ажилд Жемийн бодож төлөвлөснөөс их цаг орж, үүр цайх ойртжээ. Тэр хоёр даруйхан хөдлөх хэрэгтэй байв. Эс тэгвэл тосгоны хэн нэг нь тэднийг хараад эрх баригчдад ховлон мэдүүлнэ. Жеми дарвуулыг хурдан дэлгэж, бүх бэхэлгээг шалгалаа. Нэг юм мартсан шиг санагдаад сэтгэл нь амарч өгөхгүй байлаа. Юунд сэтгэл зовоод байгааг гэнэт ойлгоод тас тас хөхрөв. Банда өөдөөс нь гайхан харж

-Юу нь инээдтэй байна?

-Урьд нь би бүтэн тонн багаж хэрэгсэл аваад алмас эрхээр явж байсан. Одоо бол ганц луужин л байна. Энэ бүгд дэндүү амархан ажил шиг санагдаад гэхэд нь Банда

-Удахгүй чиний бодол өөр болох байх аа, Макгрегор гэж тэрээр аяархан өгүүлэв.

-Чи намайг зүгээр Жеми гэж дуудах цаг болсон баймаар юм гэсэнд Банда гайхан толгой сэгсэрч

-Чи нээрээ алс холоос ирсэн хүн... гээд дун цагаан шүд яралзуулан инээмсэглэж

-За яах вэ, эцсийн бүлэгт нэг үхэхээс хоёр үхэх юм биш... гээд нэрийг нь амталж үзэж байх шиг уруулаа өмөлзүүлэн дараа нь

-Жеми гэж аяархан дуугарав.

-Алмас олох аян замдаа орох боллоо

Хоёул салаа гүехэн усанд түлхэн оруулаад өөрсдөө дээр нь харайн гарч сэлүүрдэж эхэллээ.

Салаа жолоодож сурахад нь хэдэн минут хэрэгтэй болов. Тэд нар асар том бөглөөн дээр хөвж явах шиг санагдав. Юутай ч бол хөвж байлаа. Тэнгисийн урсгал завийг умард зүг урсгана. Жеми дарвуулаа босгоод завиа задгай тэнгис тийш заллаа. Тосгоныхныг нойрноос сэрэхэд тэдний сал аль хэдийн тэнгэрийн хаяаны цаагуур далд орсон байжээ.

-Хэрэг бүтэж байна гэж Жеми дуу алдан хашгирав. Банда толгой сэгсэрч

-Үгүй, одоохондоо бүтсэн юм алга. Энэ чинь дөнгөж эхлэл гэж хэлээд Бенгалын хүйтэн урсгалд гараа дүрэв.

Тэд дарвуулаа дэлгэн умард зүгт хөвлөө. Александрын булан, Шар мөрний адгийн дээгүүр явж өнгөрөхдөө нэгэн сүрлэг нил дэглийнээс өөр амьд амьтны бараа харсангүй. Сал дээр нь лаазалсан мах, хүйтэн тутрага, үр жимс, хоёр дашмаг ус бий боловч сэтгэл нь хөөрөөд

Юм идэж чадахгүй байлаа. Жеми өмнөөс угтаж буй аюул ослыг бодохгүй гэж өөрийгөө албаджээ. Банда ер тэгж чадахгүй байв. Банда тэнд очиж үзсэн болохоор Буу зэвсэг, зуудаг ноходтой харуул манааныхан, минатай талбайг санаад одоо ийм адал балмад явдалд автсанаа өөрөө гайхаж явлаа. Шотланд залууг хараад: "Энэ чинь надаас тэнэг эр юм. Би үхлээ гэхэд муу охин дүүгийнхээ төлөө үхнэ. Энэ хүн юуны төлөө үхэх болж байна" гэж бодлоо. Үд дундын хэрд 5-6 аварга загас үзэгдлээ. Тэр хэдэн аварга загас хурц сэлүүрээрээ ус зүсэн сал руу ойртож ирэв.

-Харав уу? Хар сэлүүртэй юм байна. Энэ чинь хүн иддэг хадарган загас байна хэмээн Банда өгүүлэв. Аварга загаснууд салыг тойрон эргэлдэж байгааг Жеми ажиглаад

-Одоо бид яадаг билээ? Гэсэнд Бандагийн зүрх хөөрөн шулсээ нэг залгиад

-Үнэнээ хэлэхэд урьд өмнө би ийм юм үзээгүй шүү, Жеми гэжээ.

Нэгэн аварга загас нуруугаараа салыг шүргэхэд сал золтой л задарч унасангүй. Жеми сэлүүр шүүрч аваад аварга загасыг чичсэнд загас сэлүүрийг нь тэр даруй тас хазав. Аварга загаснууд одоо бүр ойртож ирээд яаралгүй тойрон эргэлдэж, аварга том биеэрээ салын захыг шүргэж байлаа. Тийнхүү шүргэн түлхэх тоолонд сал аймшигтай далжийна. Сал хэдий хэдийгүй задран унаж болох байлаа.

-Биднийг живүүлээгүй байгаа дээр нь эднээс салах хэрэгтэй байна.

-Чи яаж тэгэх юм бэ?

-Надад нэг үхрийн лааз мах аваад аль,

-Тоглож байна уу даа. Ганц лааз мах эдний аманд ч үгүй, хамарт ч үгүй. Чи биднийг л идэх гэнэ.

Бас нэг түлхэхэд нь сал золтой л хөмөрсөнгүй.

-Лааз аваад аль, бушуул гэж Жеми хашгирлаа. Банда хурдан нэг үхрийн лааз мах Жемигийн гарт атгуулав.

-Талыг нь онгойлго, бушуулаарай. Банда халааснаасаа хутга гарган лаазны тагийн хагасыг онгойлгов. Жеми лаазыг авлаа. Лаазны арзайж барзайсан хурц ирмэгийг хуруугаараа тэмтэрч үзээд,

-Сайн барьж байгаарай гэж Бандад сануулав.

-Жеми салны захад сөхрөн суугаад хүлээж эхэллээ. Бараг тэр даруй амаа ангайж, хурц шүд нь ярзайн харагдсан аварга загас үзэгдэв. Жеми загасны нүдийг л харж байлаа. Лаазыг хар чадлаараа атгаж байгаад иржийсэн хурц ирмэгтэй тагаар нь аварга загасны нүдийг цавчив. Аварга загас шарвахад сал нь эгц босоод ирлээ. Орчин тойрны нь ус гэнэт улаанаар будагдав. Бусад аварга загаснууд одоо салыг тоож анхаархаа болиод шархатсан нөхөр лүүгээ ухасхийв. Аварга загаснууд түүн рүү тал талаас нь дайран тасар татхыг Жеми Банда хоёр харж байлаа. Сал нь улам улам холдсоор нэн удалгүй аварганууд харагдахаа болилоо. Банда санаа алдан

-Би нэгэн цагт энэ тухай үр ач нартаа ярьж өгнө. Үнэмших болов уу, яах бол чи юу гэж бодож байна? Гээд хоёул нүднээсээ нулимс гартал, элгээ хөштөл хөхрөлдлөө. Өдөр нэгэнт өнгөрч байх үед Жеми цагаа хараад,

-Бид алмастай эрэгт шөнө дундыг үед буух ёстой. Нар 6.15-т мандана. Тэгэхлээр бидэнд алмас түүх 4 цаг. Хүрэлцээтэй юу, Банда?

-Тэр эрэг дээрээс 4 цагийн дотор чиний цуглуулсан алмасыг 100 хүн насаараа идээд барахгүй. Бид тэр цагийг хүртэл амьд мэнд байх болтугай гэж найдна...

Өдрийн үлдсэн хэсэгт умар зүг хөвсөөр л байв. Орой тийшээ өмнө нь жижиг арал үзэгдэв. Хэмжээ нь эргэн тойрон 200 ярдаас хэтрэхгүй ажээ. Аралд ойртож очоод шивтэрийн хурц үнэрт нүднээс нь нулимс гоожиж эхлэлээ. Энд хүн суудаггүйн учрыг Жеми одоо ойлгов. Өмхий самхай нь тэсэхийн аргагүй. Энэ нь харанхуй болтол нуугдах сайхан газар болж өгнө. Жеми далбааг залж жолоодон сал нь удалгүй эрэгт тулж очлоо. Банда салаа бэхлэн аргамжиж, хоёул хуурай газар дээр буув. Энэ жижиг арал дээр хар галуу, хотон шувуу, нил дэглий гээд наад зах нь сая шувуу байх шиг санагдана. Ухаанд багтамгүй чимээ шуугианд чих дөчирч, өмхий үнэр нь амьсгаа авахын аргагүй. Тэр хоёр хэд алхаад шагайгаа хүртэл сангаст шигдлээ.

-Сал дээр буцаж очьё гэж Жемиг хоолойгоо хэржигнүүлэн хэлэхэд Банда түүнийг үг дуугүй дагав.

Тэднийг тэнгисийн хөвөөнд очихоор эргэх үед нэгэн сүрэг хотон шувуу тэнгэрт хөөрч, сууж байсан газар нь гурван хүний хүүр хэвтэж байгаа харагдав. Энэ гурван хүүр энд хэр удаан хэвтснийг хэлэхэд хэцүү. Шивтэр ихийн улмаас цогцос нь хэвээрээ хадгалагдан үлдэж, үс нь час улаан өнгөтэй болсон байлаа. Хэдэн хормын дараа Жеми Банда 2 сал дээрээ эргэн ирээд задгай тэнгис гарлаа. Тэд далбаагаа буулгаад эргээс хол хөвж байлаа.

-Шөнө дунд болтол энд хүлээе. Дараа нь хөдөлцгөөе.

Хоёул өмнө нь юу хүлээжбайгааг дор дороо бодолхийлэн суулгаав. Наран жаргаж, тэнгэрийг ухаанд багтамгүй сонин өнгөөр буджээ. Тэгснээ гэнэт харанхуй болов.

Тэд 2 цаг хүлээгээд дараа нь далбаагаа босгов. Сал нь дорно зүг, үл үзэгдэхэрэг рүү хөвж эхлэлээ. Үүлний цаанаас саран цухуйж хавь ойрыг цайвар гэрлээр гийгүүлэв. Сал хурд авч эхлэв. Алсад эргийн дүрс бүдэг бадаг үзэгдэнэ. Салхи хүчтэй үлээж, дарвуул нь хүлхийн сал эргийн зүг хурдаллаа. Тэд удалгүй газрын бараа харав. Өдий төдий асга хад. Ийм холоос хүртэл асар том давалгаан хад мөргөн зад үсрэх нь харагдаж, сонсдож байлаа. Холоос харахад ч гэсэн аймаар сүртэй. Ойртоод очиход ямар байхыг Жеми сэтгэлдээ төсөөлж ядав.

-Эрэг дээр нээрээ харуул хамгаалалт байхгүй юм биз? Гэж шивгэнэн асуусанд Банда хариу дуугарсангүй, өмнөө байгаа хад чулууг заав.

Юу гэж хэлэх гэснийг Жеми ойлголоо. Энэ хад чулуу хүний бодож зохиосон ямарч урхи занганаас илүү аюултай. Энэ бол тэнгисийн манаа бөгөөд хэзээ ч амардаггүй, хэзээ ч унтдаггүй манаа. Тэгээд осолд орох хүн амьтныг үг дуугүй хүлээж байдаг.

"За гайгүй. Энэ удаа бид энэ лүглэгэр лүглэгэр харуул манааг мэхэлж чадна. Бид дээгүүр нь хөвөөд гарна" гэж Жеми бодлоо. Тэд салаараа нилээд газрыг хөвж туулсан, энэ хэсгийг ч хөвөөд л өнгөрнө. Эрэг бүр ойртож, лут их долгионы хяр дээр дүүлж байгаагаа мэдрэв. Банда шураг модноос зуурч

-Бид хэт хурдан урагшилж байна гэлээ.

-Санаа бүү зов. Ойртож очоод далбаагаа буулгахад хурд саарна. Бид хад чулууны дээгүүр амархан хөвөөд гарна гэж Жемиа хариулав.

Үргэлжлэл дараагийн дугаарт...